



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

МУБИС-ийн гадаад оюутны гарын авлага

*(Магистрант, докторантуудад
зориулав)*

УЛААНБААТАР
2024

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ



МУБИС-ийн гадаад оюутны гарын авлага

(Магистрант, докторантуудад зориулав)

Улаанбаатар хот

2024 он

МУБИС-ийн гадаад оюутны гарын авлага

Боловсруулсан:

Б. Норжинбуу /МУБИС МБУС Мэдээлэл зүйн тэнхимийн багш/

Ц. Баттогтох /МУБИС МБУС Мэдээлэл зүйн тэнхимийн эрхлэгч/

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

А. Төрбат /МУБИС МБУС Мэдээлэл зүйн тэнхимийн багш/

Редактор:

Д. Цэдэвсүрэн /МУБИС Сургалт, цахим шилжилтийн хэлтсийн дарга/

Англи хэлний редактор: М. Булганцэцэг /МУБИС НХУС Англи хэлний тэнхимийн багш/

Хятад хэлний редактор: Г. Цогзолмаа /МУБИС Гадаад харилцааны албаны дарга/

Өмнөх үг

Дал гаруй жилийн түүхтэй Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн нэрийн өмнөөс та бүхэнтэй мэндчилж байгаадаа баяртай байна.

Боловсрол бол хүний хөгжил, бидний ирээдүй бөгөөд мэдэх, чадах, амьдрах гэсэн баримтлалд тулгуурладаг. Боловсролын хөгжлийн суурийг орчин цагийн хувьсал, хүний хөгжил, төрийн бодлоготой холбож, шинжлэх ухааны мэдлэгийг практик хэрэглээтэй хослуулах нь чухал. Дэлхий нийтээрээ хувь хүний ялгаатай байдлыг ойлгож, тэгш хүртээмжтэй боловсрол олгохыг эрхэмлэж байна. Зөв хандлагатай, суралцахуйг эзэмшсэн, хийж бүтээх эрмэлзэлтэй, амьдрах чадвартай иргэнийг бий болгох цаг үеэ мэдэрсэн бүтээлч, зөөлөн ур чадвартай, багш нарыг бэлтгэхээр бид ажиллаж байна. Мөн нийгэмд эрэлт хэрэгцээтэй бусад олон мэргэжлээр МУБИС боловсон хүчин бэлтгэсээр ирсэн.

Манай эрдмийн хамт олон 21 дүгээр зууны боловсролын салбарын хамгийн чухал хүчин зүйлс болох улс төрийн хүчин зүйлс, эдийн засгийн хүчин зүйлс, нийгмийн хүчин зүйлс, технологийн хүчин зүйлс (PEST) болон цаг үеийн хувьслыг даган багшийн ур чадварт тавигдаж буй технологийн дэвшил, цахим орчин, хиймэл оюунд суралцах, хурдтай байх шаардлагуудыг хөтөлбөрийн шинэчлэлдээ тусган ажиллаж байна.

Дэлхийн тогтвортой хөгжил, улс орныхоо өрсөлдөх чадварт бодитой хувь нэмэр оруулах шинэ үеийн бүтээлч багш, инновац хөгжүүлэгч, энтрепренер сэтгэгчдийг МУБИС бэлтгэхийг зорьж байна.

Бидэнтэй хамтран ажилладаг түншлэгч байгууллагууд, манай сургуулийг сонгон суралцаж буй, суралцахаар зорьж буй залуустаа амжилт хүсье. Сайхан нийгмийг хамтдаа бүтээе.

МУБИС-ИЙН РЕКТОР, ПРОФЕССОР Ж. БАТБААТАР

Агуулга

Өмнөх үг	5
БҮЛЭГ I. МУБИС-ийн ТАНИЛЦУУЛГА.....	6
МАТЕМАТИК БАЙГАЛИЙН УХААНЫ СУРГУУЛЬ	12
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ	14
ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ.....	16
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	18
БАГШИЙН СУРГУУЛЬ	20
БИЕИЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ.....	21
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	23
АРХАНГАЙН БАГШИЙН СУРГУУЛЬ	25
БАЯН-ӨЛГИЙН БАГШИЙН СУРГУУЛЬ.....	26
НОМЫН САН	28
ДОТУУР БАЙР	31
БҮЛЭГ II. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	33
Сургалтын нэр, томъёоны тайлбар:	33
Ахисан түвшний сургалтын зохион байгуулалт:	34
МУБИС-ийн Сургалтын удирдлага мэдээллийн систем	34
“OFFICE 365” онлайн программ.....	39
БҮЛЭГ III. МАГИСТРЫН СУРГАЛТ.....	41
1. Элсэлт, бүртгэл.....	42
Бүртгүүлэгчдэд тавих шаардлага:	42
Бүрдүүлэх бичиг баримт:	42
Элсэлтийг баталгаажуулах:.....	43
2. Суралцах үйл явц.....	44
Суралцах хугацаа:	44
Сургалтын төлөвлөгөө:	44
Хичээл сонголт:.....	46
Сургалтын төлбөр	47
Гадаад хэлний шалгалт.....	47
Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө	47
3. Төгсөх үйл явц	48
Магистрын ажил:	48
Магистрын ажлын урьдчилсан хамгаалалт:	48
Магистрын ажлын жинхэнэ хамгаалалт:	48
Магистрын ажил хүдээлгэж өгөх	49
Магистрын зэрэг олгох, төгсөлт	49
БҮЛЭГ IV. ДОКТОРЫН СУРГАЛТ	50
1. Элсэлт, бүртгэл.....	51
Бүртгүүлэгчдэд тавих шаардлага:	51
Бүрдүүлэх бичиг баримт:	51

Элсэлтийг баталгаажуулах:	52
2. Суралцах үйл явц:	53
Суралцах хугацаа:	53
Сургалтын төлөвлөгөө:	53
Хичээл сонголт:	55
Сургалтын төлбөр	55
Гадаад хэлний шалгалт:	56
Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө:	56
3. Төгсөх үйл явц	57
Докторын диссертац:	57
Докторын диссертац урьдчилсан хамгаалалт:	57
Докторын диссертац хуулбарлалт шалгах:	57
Докторын диссертац жинхэнэ хамгаалалт:	58
Докторын диссертац хүлээлгэж өгөх	58
Докторын зэрэг олгох, төгсөлт	58
БҮЛЭГ V. МУБИС-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ	59
Мэдлэг, чадварыг үнэлж, дүгнэх:	59
Чөлөө авах:	61
Сургуулиас чөлөөлөх:	61
Шилжилт, хөдөлгөөн:	61
Магистрант, докторант туслах ажилтнаар ажиллах:	62
Сургуулиас олгох албан ба албан бус бичиг баримт	64
БҮЛЭГ VI. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ	66
Улаанбаатар хот:	66
Гадаад оюутны визны мэдээлэл	68
Гадаад оюутанд хэрэгтэй мэдээ, мэдээлэл	69
Аюул тохиолдсон үед шаардлагатай дугаарууд:	71
Ашигласан материал:	72

БҮЛЭГ I. МУБИС-ийн ТАНИЛЦУУЛГА

МАТЕМАТИК БАЙГАЛИЙН УХААНЫ СУРГУУЛЬ

НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ

БАГШИЙН СУРГУУЛЬ

БИЕЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

АРХАНГАЙН БАГШИЙН СУРГУУЛЬ

БАЯН-ӨЛГИЙН БАГШИЙН СУРГУУЛЬ

НОМЫН САН

ДОТУУР БАЙР

5

6

12

14

16

18

20

21

23

25

26

28

31

Бүлэг I

Бүлэг II

Бүлэг III

Бүлэг IV

Бүлэг V

Бүлэг VI

БҮЛЭГ I. МУБИС-ийн ТАНИЛЦУУЛГА

МУБИС-ийн алсын хараа, зорилго, үнэт зүйл:

- **Алсын хараа:**

Багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх.

- **Эрхэм зорилго:**

Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч багш, боловсролын болон шинжлэх ухааны бусад салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах

- **Зорилго:**

Эрдэм шинжилгээ, инновац, сургалтын арга зүй, технологийг хөгжүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.

- **Үнэт зүйл:**

1. Сурах арга барилтай, хүнлэг, ёс зүйтэй оюутан
2. Судлан шинжлэх, суралцахуйг хөтлөх эрдэмтэн багш
3. Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай бүтээлч төгсөгч
4. Бүтээлч, хариуцлагатай, нэгдмэл хамт олон
5. Хөгжил дэвшил, үнэт зүйлийг эрхэмлэгч зөв удирдлага
6. Сургалт, судалгаа, инновацын таатай орчин
7. Үр дүнд суурилсан тогтолцоо, эдийн засгийн нөөц, чадамж

МУБИС-ийн түүхэн замнал:

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь 1951 онд анх Улсын Багшийн Институт нэртэйгээр Засгийн газрын хуучин байранд /одоогийн хичээлийн I байр/ анх үүдээ нээсэн цагаас хойш тасралтгүй хөгжсөөр өдгөө Монгол Улсын Боловсролын Их Сургууль болон өргөжжээ. Тухайн үед Монгол хэл, Уран зохиол, Тоо физик, Түүх, Байгаль- Химийн мэргэжлээр 8 багш, 212 оюутан, 2000 орчим номтой номын сантайгаар хичээл эхэлж байсан.


- 1951 он Улсын Багшийн Институт
- 1957 он Улсын Багшийн Дээд (УБДС)
- 1991 он Улсын Багшийн Их Сургууль (УБИС)
- 2004 он Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)

Энэхүү 70 гаруй жилийн түүхийн хугацаанд факультет, тэнхимийн бүтцийн хувьд дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

- 1961 он 4 факультет, 8 тэнхим

- 1971 он 6 факультет, 18 тэнхим
- 1981 он 6 факультет, 20 тэнхим
- 1991 он 6 факультет, 19 тэнхим
- 2001 он 9 бүрэлдэхүүн сургууль, 19 тэнхим
- 2011 он 12 бүрэлдэхүүн сургууль, нэг харьяа сургууль, 44 тэнхим
- 2014 он 5 бүрэлдэхүүн сургууль, нэг харьяа сургууль, нэг лицей, нэг цэцэрлэг, 35 тэнхим
- 2017 он 8 бүрэлдэхүүн сургууль, нэг лицей, нэг цэцэрлэг, 35 тэнхим
- 2023 оны байдлаар МУБИС нь 9 бүрэлдэхүүн сургууль, лицей, цэцэрлэг, 46 тэнхимтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

МУБИС-ийн бүтэц:



МУБИС-ийн Сургалт, хамтын ажиллагааны газар:

Сургалт хамтын ажиллагааны газар нь бакалавр, магистр, докторын болон бусад төрлийн сургалтын бодлого, сургалтын өдөр тутмыг үйл ажиллагааны хэрэгжилт, бүх төрлийн сургалтын үнэлгээ, тоон болон чанар шинжилгээ, статистик, бүх түвшин, хэлбэрийн сургалтын элсэлт, төгсөлт, оюутан суралцагчийн хөгжил, багшлах дадлага, сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл тусламж, оюутны клуб, цагийн ажил эрхлэлт, нийгэмд чиглэсэн сайн дурын ажил, цахим сургалтыг хэрэгжүүлэх, сургуулийн МХТ-ийн орчин болоод сургалтын удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах, профессор багшийн мэргэжил, арга зүйн хөгжил зэрэг ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Тус газар нь дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхний нэгжүүдтэй. Үүнд:

- **Сургалт цахим шилжилтийн хэлтэс:**

Бакалаврын бүх хэлбэрийн сургалтын бодлогыг хэрэгжүүлэх, сургалтын өдөр тутмыг үйл ажиллагааны хэрэгжилт, сургалтын үнэлгээ, тоон болон чанар шинжилгээ, статистик, бакалаврын сургалтын элсэлт, төгсөлт, багшлах дадлага, сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл тусламж, цахим сургалтыг хэрэгжүүлэх, сургуулийн МХТ-ийн орчин болоод сургалтын удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагааны өдөр тутмын найдвартай байдлыг хангах, профессор багшийн мэргэжил, арга зүйн хөгжил зэрэг ажлыг нэгдсэн бодлого удирдлагаар хангах үндсэн үүрэгтэй. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 108, 109 тоот, Холбоо барих утас: 7775115-1035

- **Ахисан түвшний хөтөлбөрийн алба**

Магистр, докторын сургалтын бодлогыг хэрэгжүүлэх, ахисан түвшний сургалтын өдөр тутмыг үйл ажиллагааны хэрэгжилт, сургалтын үнэлгээ, ахисан түвшний сургалтын элсэлт, төгсөлт, сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл тусламжид хамруулах, ахисан түвшний гадаад суралцагчдын дунд соёл, олон нийт, соёлын солилцооны чиглэлийн ажлыг явуулах зэрэг ажлыг нэгдсэн бодлого удирдлагаар хангах үндсэн үүрэгтэй. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 108, 109 тоот, Холбоо барих утас: 7775115-1035

- **Оюутны хөгжил, үйлчилгээний төв**

Бакалаврын оюутны бие хүний хөгжил, тэдний санаачлан хэрэгжүүлж буй сайн дурын ажил, оюутны клуб, сайн дурын , цагийн ажил, хөдөлмөр эрхлэлт, карьер хөгжлийн асуудлыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 108, 109 тоот, Холбоо барих утас: 7775115-1035

МУБИС-ийн Эрдэм шинжилгээ инновацын газар:

Тус газар нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн бодлого боловсруулж, багш, оюутны эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, эрдмийн бүтээл туурвих ажлыг дэмжих, эрдмийн цолтой багш, ажилтны хувийг нэмэгдүүлэх, дотоод, гадаадын хамтын ажиллагаа харилцаа холбоог өргөжүүлэх хүрээлэн, номын сан, төвүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах, антрепренёршип боловсрол болон судалгааны шинэ чиглэлийг хөгжүүлэх зэрэг ажлыг аргазүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 211, 211а тоот, Холбоо барих утас: 77775115 /1030/

МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газар:

МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь санхүү, хөрөнгө оруулалт аж ахуйн хэлтэс, сургалтын орчны дэмжлэг үйл ажиллагааны төв гэсэн 2 чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- **Санхүү, хөрөнгө оруулалт аж ахуйн хэлтэс**

Санхүү, хөрөнгө оруулалт худалдан авалтын чиглэлээр өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, төсөв боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр хангах, үнэлэх, хэрэгжилтэд хяналт тавих, сургуулийн санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүртгэх, тайлагнах, холбогдох хууль дүрэм журмын дагуу тайлан мэдээ, мэдээллийг бэлтгэж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хаяг: МУБИС-ийн 1-115, 6-106, 4-104, 3-313, 10-1016, 7-35а, 2-206, 8-503, тоот, Холбоо барих утас: 77775115-1035

- **Сургалтын орчны дэмжлэг үйл ажиллагааны төв**

МУБИС-ийн нийтлэг үйлчилгээний ажилтан, ажилчдыг удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны бодлого чиглэлээр ханган ажиллах үүрэгтэй. Энэхүү төвийн үйл ажиллагааны гол зорилго нь МУБИС-ийн багш, ажилтан, ажилчид, оюутан, суралцагчид ая тухтай, цэвэр цэмцгэр аюулгүй орчинд ажиллах, суралцах, мөн оюутны болон багш ажилчдын байранд тохь тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд оршино. Тус төв нь 200 гаруй нийтлэг үйлчилгээний ажилтан ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 108, 109 тоот, Холбоо барих утас: 77775115-1035

МУБИС-ийн Тамгын газар:

МУБИС-ийн Тамгын газар нь байгууллагын бодлого төлөвлөлт, өдөр тутмын үйл ажиллагаа, архив, хүний нөөц, хууль эрх зүй, хяналт шинжилгээ, судалгаа, гадаад харилцаа, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр захиргааны үйл ажиллагаа явуулж байна. Тус газар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хаяг: МУБИС-ийн 1-р байрны 108, 109 тоот, Холбоо барих утас: 77775115-1035

МАТЕМАТИК БАЙГАЛИЙН УХААНЫ СУРГУУЛЬ*Түүхэн товчоо:*

1951 онд МУБИС-ийг үүсгэн байгуулагдах үеийн анхны салбарууд болох Тоо физик болон Байгаль дэлхий судлал нь өдгөө Математик, Байгаллийн ухааны сургууль (МБУС) болон өргөжин хөгжиж байна. Өдгөө МБУС нь 7 тэнхим, 2 төв, хөтөлбөрийн алба гэсэн нэгжтэйгээр эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Математикийн багш
- Мэдээлэл зүйн багш
- Физикийн багш
- Химийн багш
- Биологийн багш
- Хими, биологийн багш
- Газарзүйн багш
- Биологи, Газар зүйн багш
- Биологи, Эрүүл мэндийн багш
- Эрүүл мэндийн багш
- Программ хангамжийн инженер
- Экологич

Магистрын хөтөлбөр:

- Математик боловсрол
- Мэдээлэл зүйн боловсрол
- Химийн боловсрол
- Биологийн боловсрол
- Физик боловсрол
- Газар зүйн боловсрол
- Биологи
- Хими
- Физик
- Математик
- Газар зүй
- Мэдээллийн технологи

Докторын хөтөлбөр:

- Математик
- Биологи
- Хими

- Физик
- Газар зүй

Судалгааны тэргүүлэх чиглэл: Математик, Байгалийн Ухааны Боловсрол

Хавсарга чиглэл:

- Дискрет математик
- Функциональ анализ
- Компьютерын ухаан, хавсарга математик, хавсарга технологийн судалгаа
- Монгол орны түүхий эдийн дахин боловсруулах судалгаа
- Байгаль хамгаалал, биологийн төрөл зүйлийн судалгаа
- Боловсролын хэмжил зүй
- Биофизик

Хаяг: Монгол 14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бээжингийн гудамж, МБУС нь МУБИС-ийн хичээлийн III, II, XII байрууд

Холбоо барих утас: 7777-96-69 /12-00, 12-01/

НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

1951 онд Хэл бичгийн тэнхим байгуулагдаж, 1964 оноос Монгол хэл-уран зохиолын факультет болон өргөжихдөө Монгол хэлний тэнхим, Уран зохиолын тэнхим гэсэн 2 биеэ даасан тэнхим болсон. 2006 онд Сэтгүүлзүйн тэнхим байгуулагдсан бөгөөд 2001 оноос Монгол судлалын сургууль байгуулагдаж, 3 тэнхимтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байжээ.

1951 онд Түүх, нийгмийн ухааны тэнхим байгуулагдаж, 1965 онд 2 тэнхим болон тусгаарлаж, 2001 онд Түүх, нийгмийн ухааны сургууль байгуулагджээ.

1952 онд Орос хэлний тэнхим, 1991 онд Англи хэлний тэнхим, 1993 онд Англи, Герман хэлний тэнхим, 1998 онд Дорно дахины хэлний тэнхим байгуулагдаж, 2001 онд Гадаад хэлний сургууль байгуулагджээ.

2014 оноос дээрх 3 сургууль нэгдэж, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Өдгөө НХУС нь 9 тэнхим, 2 төв, хөтөлбөрийн алба гэсэн нэгжтэйгээр эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Нийгмийн ухааны багш
- Түүхийн багш

- Түүх, нийгмийн ухааны багш
- Архив, албан хэрэг хөтлөлт
- Түүх, соёлын аялал жуулчлал
- Монгол хэл, уран зохиолын багш
- Хэл, уран зохиол судлаач
- Англи хэлний багш
- Орос хэлний багш
- Хятад хэлний багш
- Солонгос хэлний багш
- Герман хэлний багш
- Япон хэлний багш
- Герман, англи хэлний багш
- Орос, англи хэлний багш
- Япон, англи хэлний багш
- Сэтгүүлч

Магистрын хөтөлбөр

- Сэтгүүл зүй
- Түүхийн боловсрол
- Философийн боловсрол
- Улс төр, эрх зүйн боловсрол
- Монгол хэл, уран зохиолын боловсрол
- Гадаад хэлний боловсрол
- Улс төр судлал
- Утга зохиол судлал
- Гадаад хэл шинжлэл
- Түүх
- Философи
- Социологи
- Хэл шинжлэл
- Нийгмийн ухааны боловсрол

Докторын хөтөлбөр

- Хэл шинжлэл
- Түүх
- Улс төр судлал
- Утга зохиол судлал
- Сэтгүүл зүй, мэдээлэл
- Философи
- Гадаад хэл шинжлэл

Судалгааны тэргүүлэх чиглэл: Монгол судлал

Хаяг: МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Хичээлийн 4-р байр

Холбоо барих утас: 11-328450

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ*Түүхэн товчоо:*

1958 онд Улсын Багшийн дээд сургуульд Зураг-хөдөлмөрийн багшийн ангийг нээж сууриа тавьсан тус сургууль өдгөө мэргэжлийн 3 тэнхим, 48 багш, ажилтан, гадаад, дотоодын 800 гаруй оюутан, тусгайлан тоноглогдсон кабинет, лабораторитойгоор эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг явуулж байна. Багш ажилтны 40 гаруй хувь нь эрдмийн зэрэг цолтой ба дүрслэх урлаг, дизайн, уламжлалт технологийн чиглэлээр суурь, хавсарга судалгаа явуулж, дүрслэх урлаг, зураг зүй дизайн, дизайн технологийн багш, график болон хувцасны дизайны бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн, мөн магистр, докторын сургалтыг явуулж байна.

Сургалтын технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, сургалтын орчин, менежментийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, багшлах боловсон хүчнийг хөгжүүлэн, чадваржуулахад анхааран ажиллахын зэрэгцээ багш нарын мэргэжил, бүх нийтийн урлаг, дизайн, технологийн боловсролыг дээшлүүлэх үүргийг хүлээн ажиллаж байна. Мөн ОХУ, БНХАУ, Япон, Польш, БНСУ зэрэг орнуудын их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж багш, оюутан солилцоо болон 2+2 хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Одоо Дүрслэх Урлагийн тэнхим, Технологийн тэнхим, Дизайн зураг зүйн тэнхимтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Дүрслэх урлагийн багш
- Дизайн, зураг зүйн багш
- Дизайн, технологийн багш
- График дизайн
- Мультимедиа дизайн
- Хувцас дизайн

Магистрын хөтөлбөр:

- Дизайн зураг зүйн боловсрол
- Урлагийн боловсрол
- Дизайн технологийн боловсрол
- Уран зураг
- График дизайн
- Урлаг судлал

Докторын хөтөлбөр:

- Урлаг судлал

Хаяг: Монгол улс 14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 14, МУБИС-ийн хичээлийн VII байр

Холбоо барих утас: (976-11) 310923, 312561, 7777-6226 /2009, 2010/

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ*Түүхэн товчоо:*

Боловсрол судлалын сургууль нь 1951 оны 12-р сарын 10- ны ректорын тушаалаар Улсын Багшийн Институтэд анх долоон кабинет байгуулсны нэг нь Сурган хүмүүжүүлэх кабинет юм. Өдгөө Боловсрол Судлалын Сургууль үүсэн хөгжих үндэс суурь нь байлаа. Боловсрол Судлалын Сургууль нь хөтөлбөрийн алба, 6 тэнхим, судалгааны 2 төв гэсэн бүрэлдэхүүнтэйгээр эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Боловсрол судлаач
- Сэтгэл судлаач
- Нийгмийн ажилтан
- Сэтгэл судлаач, сургуулийн сэтгэл зүйч
- Нийгмийн ажил, хүүхдийн арга зүйч
- Насан туршийн боловсролын багш
- Тусгай хэрэгцээт боловсролын багш

Магистрын хөтөлбөр:

- Боловсрол судлал
- Боловсролын удирдлага
- Боловсролын технологи
- Сэтгэл судлал
- Нийгмийн ажил
- Насан туршийн боловсрол
- Тусгай хэрэгцээт боловсрол
- Багш, бизнес судлалын боловсрол

Докторын хөтөлбөр:

- Боловсрол судлал
- Боловсролын удирдлага

- Сэтгэл судлал

Судалгааны тэргүүлэх чиглэл:

- Боловсрол судлал
- Сэтгэл судлал
- Боловсролын удирдлага
- Нийгмийн ажил
- Тусгай хэрэгцээт боловсрол
- Насан туршийн боловсрол

Хаяг: Монгол 14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу
14, МУБИС-ийн хичээлийн IX байр

Холбоо барих утас: (976-11) 70120013, 77776116 /1061/

БАГШИЙН СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

1922 оны намар ардын Засгийн газрын 64 дүгээр тогтоол, Дотоод яамны шийдвэрээр нийслэл хүрээнд аймаг, хошуунаас нас залуу, бичиг үсэгт боловсронгуй хүмүүсийг цуглуулж, 4 сарын хугацаанд сурган, тэдэнд улсын сангаас 30 лан мөнгө олгож, ардыг гэгээрүүлэх үйлсэд хүчин зүтгүүлэх болсноор “Багшийн сургууль” үүсэн байгуулагдсан түүхтэй.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Бага ангийн багш
- Хөгжмийн багш

Магистрын хөтөлбөр:

- Бага боловсролын заах арга
- Урлагийн боловсрол

Судалгааны тэргүүлэх чиглэлүүд:

- Бага боловсролын болон хөгжмийн боловсролын сургалтын онол, арга зүйн судалгаа, инновац
- Сургуулийн бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил ба тэгш хамруулах боловсрол
- Бага боловсролын ба хөгжмийн багшийн хөгжлийн судалгаа

Хаяг: Монгол улсын Боловсролын их сургууль, Бага тойруу-14, МУБИС-ийн хичээлийн V байр

Холбоо барих утас: +976-7777-6464, +976-8864-4188

БИЕНИЙ ТАМИРЫН СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

Биений тамирын сургууль нь Монгол улсын биений тамир, спортын салбарт дээд боловсролтой мэргэжилтнийг 1955 оноос бэлтгэж эхэлсэн төрийн өмчийн сургууль юм. 1955- 1956 оны анхны хичээлийн жилд Улсын багшийн институтэд биений тамирын багшийг гурван жилийн сургалтаар бэлтгэж байсан бол 1957 оноос суралцах хугацааг 4 жил болгож, улмаар 1960 оноос дээд боловсролтой биений тамирын багшийг бэлтгэх болсон. Өдгөө тус сургууль нь 800 гаруй оюутан, 40 орчим профессор багштайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж, хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж байна. Энэхүү 60 гаруй жилийн хугацаанд Монголын спортын түүхэн дэх баялаг түүхийг хамтдаа бүтээлцсээр ирлээ. Биений тамирын сургуулийн үе үеийн багш, оюутан, төгсөгчдийн дундаас төрөн гарсан Монгол улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, спортын гавьяат тамирчин, спортын гавьяат багш, дасгалжуулагч, Олимп, дэлхийн аваргуудаараа бид бүхэн үргэлж бахархдаг билээ.

Багш мэргэжилтний үнэт зүйл, багш боловсролын хэрэгцээнд суурилан, мэргэжлийн өндөр мэдлэг, чадвартай “Биений тамирын багш”-ийг бэлтгэх нь манай сургуулийн үндсэн зорилт юм. Үүний зэрэгцээ нрээдүйн шилдэг тамирчдыг дасгалжуулах онол, арга зүйн чадвар бүхий спортын тодорхой төрлийн дасгалжуулагчийг 1990-ээд оноос эхлэн бэлтгэж байна. Биений тамир, спортын нийгэмд гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөн тэлэхийн хэрээр манай сургуулийн мэргэжилтэн бэлтгэх чиглэл өргөжиж байгаагийн илрэл нь спортын сэтгүүлч, мөн спортын аялал жуулчлалын мэргэжилтнийг мэргэшүүлэн сургаж буй сургууль болсноос тод харагдана. Бид тамирчдын нөр их хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тэдэнд мэргэжил, боловсрол олгохоор “тамирчны карьерын дараах сургалт”-ыг хариуцан зохион байгуулж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн биений тамирын агш нарыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх ажилд манлайлан оролцсоор ирлээ.

Одоо Биений тамир, спортын онол аргазүйн тэнхим, Спортын тэнхим, Биений тамирын тэнхимтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Биений тамирын багш
- Биений тамирын арга зүйч
- Биений тамирын багш, арга зүйч
- Спортын дасгалжуулагч, биений тамирын багш
- Спортын дасгалжуулагч
- Спорт аялал жуулчлал
- Спортын сэтгүүлч

Магистрын хөтөлбөр:

- Биений тамирын боловсрол
- Спортын дасгалжуулагч

Судалгааны тэргүүлэх чиглэл:

- Биений тамир, спортын боловсрол
- Монгол хүний эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийн судалгаа
- Биений тамир, спортын боловсрол
- Спортын анагаах ухаан, био механик

Хаяг: Монгол 14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу
14, МУБИС-ийн хичээлийн III байр

Холбоо барих утас: (976-11) 322106, 77775445 /2200/

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

Цэцэрлэгийн багш бэлтгэх ажил 1941 онд ГЯ-ны дэргэд цэцэрлэгийн хүмүүжүүлэгчийн 3-6 сарын курс нээж 248 хүмүүжүүлэгч бэлтгэснээр анх эхэлжээ.

1951-1952 оны хичээлийн жилээс Улаанбаатар хотын Багшийн сургуулийн дэргэд 1 жилийн курс нээж 48 хүмүүжүүлэгч, улмаар 1953-1954 оны хичээлийн жилээс 3 жилийн сургалтаар 218 цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багш бэлтгэжээ.

Ардын боловсролын яамны сайдын 1962 оны 6-р сарын 12- ны өдрийн 172 тоот тушаалаар Багшийн сургуулиас цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багшийн ангийг тусгаарлан “Цэцэрлэгийн багш нарыг бэлтгэх сургууль”-ийг байгуулжээ.

1962-1963 оны хичээлийн жилээс Цэцэрлэгийн багшийн сургууль нэртэй бие даасан сургууль байгуулагдаж тусгай дунд боловсролтой цэцэрлэгийн багш арга зүйч бэлтгэжээ.

1995-1996 оны хичээлийн жилээс хөгжмийн багшийн сургуультай нэгдэж сурган хүмүүжүүлэх ухааны коллеж нэртэй 2 факультеттай ажиллажээ. Ректорын 1997 оны 399 тоот тушаалаар нэрийг нь өөрчилж цэцэрлэгийн багшийн коллеж, 2001 оны 287 тоот тушаалаар цэцэрлэгийн багшийн сургууль нэртэй болсон.

1998-1999 оны хичээлийн жилээс хөгжмийн факультет соёлын коллежид шилжиж, цэцэрлэгийн багш арга зүйч бэлтгэх факультет нь УБИС-ийн бүрэлдэхүүний сургууль хэвээр үлдэв.

Цэцэрлэгийн багшийн сургууль тусгай боловсролтой 5141 хүмүүжүүлэгч багш, 119 дуу хөгжмийн багш бэлтгэжээ. 1995 оноос цэцэрлэгийн багш арга зүйч мэргэжлээр дипломын дээд боловсролтой, 1999 оноос бакалаврын боловсролтой 1195 багш арга зүйч, дуу хөгжмийн 29 багш бэлтгэсэн байна.

Цэцэрлэгийн багшийн сургууль байгуулагдсанаасаа хойш бүгд 7177 мэргэжилтэн бэлтгэж улсын хэмжээний цэцэрлэгийн багш нарын 90 орчим хувийг өөрийн төгсөгчдөөр хангаж байна.

Ректорын 2004 оны 165 тоот тушаалаар цэцэрлэгийн багшийн сургуулийг Сургуулийн Өмнөх Боловсролын коллеж гэж нэрлэдэг болжээ.

1994-1995 оноос 10-р анги төгсөгчдийг элсүүлж, 4 жил сурган бакалаврын зэрэгтэй багшийг, тусгай дунд боловсролтой цэцэрлэгийн багш нарыг 1,5 жил, харин 2010-2011 оноос 1 жил болгон богиносгон шаталсан сургалтад хамруулж бакалаврын зэрэгтэй багшийг бэлтгэж байна. 2014 оноос 10-р анги төгсөгчдийг элсүүлж, 3,5-4 жил сурган бакалаврын зэрэгтэй багшийг бэлтгэж эхэлсэн.

1996-1997 оны хичээлийн жилээс МУБИС-ийн бүрэлдэхүүн сургууль болж өргөжсөн.

2006-2007 оноос магистрантурын сургалтыг зохион байгуулсан.

Тус сургууль нь 2001 онд байгууллагын, 2006 онд Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр “Цэцэрлэгийн арга зүйч” сургалтын хөтөлбөрөө батлуулсан, 2020 онд “Багш, сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн.

2009-2010 оны хичээлийн жилээс багш болон багш бус мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөгчдөд цэцэрлэгийн арга зүйч мэргэжлийг эзэмшүүлж байна.

Одоо Арга зүйн тэнхим, Урлагийн тэнхим, Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын тэнхим гэсэн 3 тэнхимтэй, судалгаа, арга зүйн төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Багш, сургуулийн өмнөх боловсролын багш
- Цэцэрлэгийн хөгжмийн багш

Магистрын хөтөлбөр:

- Сургуулийн өмнөх боловсрол

Судалгааны тэргүүлэх чиглэл:

- Бага насны хүүхдийн цогц хөгжил
- Сургуулийн өмнөх боловсролын агуулга, аргазүйн шинэчлэл

Хаяг: Монгол 14191 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17 хороо, Дилав хутагт
Жамсранжавын гудамж, МУБИС-ийн Сургуулийн Өмнөх Боловсролын Сургууль

Холбоо барих утас: 77774664 /2406/

АРХАНГАЙН БАГШИЙН СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

Архангайн Багшийн сургууль нь анх 1951 онд Багш нарыг бэлтгэх сургууль нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1990 онд Багшийн коллеж, 2010 оноос МУБИС-ийн Архангайн Багшийн сургууль болж өргөжсөн юм. Манай сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол улсын төвийн болон баруун бүсийн багшлах боловсон хүчнийг нэр төртэйгээр бэлтгэж ирсэн түүхэн уламжлалтай.

Одоо Бага боловсролын тэнхим, Математик, Байгалийн ухааны тэнхим, Монгол хэл-Уран зохиолын тэнхим, Боловсрол судлалын тэнхимтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Бага ангийн багш
- Сургуулийн өмнөх насны боловсролын багш
- Монгол хэл, уран зохиолын багш
- Математикийн багш
- Түүх, нийгмийн ухааны багш
- Англи хэлний багш
- Нийгмийн ажилтан
- Сэтгэл судлаач

Магистрын хөтөлбөр:

- Боловсрол судлал

Судалгааны тэргүүлэх чиглэл:

- Нийгэм, хүмүүнлэгийн ухаан, сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын агуулга арга зүйн судалгаа

Хаяг: Монгол улс, Архангай аймаг, МУБИС-ийн Архангайн багшийн сургуулийн хичээлийн байр

Холбоо барих утас: +976 70333123

БАЯН-ӨЛГИЙН БАГШИЙН СУРГУУЛЬ

Түүхэн товчоо:

Анх 1990 онд эх орны баруун хязгаар Баян-Өлгий аймагт Багш, соёлын ажилтныг бэлтгэх тусгай мэргэжлийн дунд сургууль болон байгуулагдаж, 1996-2010 онд МУБИС-ийн харьяа Баян-Өлгий аймаг дахь Багшийн коллеж, 2010-2022 онд Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн МУБИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль болж статус нь өргөжин сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулж байна. Өдгөө хичээлийн 2 байр, номын сан, биеийн тамирын заал, оюутны дотуур байр зэрэг барилга байгууламжтай. Боловсрол судлал, аргазүйн тэнхим, Байгаль нийгмийн ухааны тэнхим, Хөтөлбөрийн алба гэсэн 3 нэгжтэйгээр ажиллагаагаа явуулж байна.

Хөтөлбөр:

Мэргэжлийн тэнхимүүд нь дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бакалаврын хөтөлбөр:

- Бага ангийн багш
- Сургуулийн өмнөх насны боловсролын багш
- Монгол хэл, уран зохиолын багш
- Математикийн багш
- Түүх, нийгмийн ухааны багш
- Англи хэлний багш
- Нийгмийн ажилтан
- Сэтгэл судлаач

Судалгааны тэргүүлэх чиглэл:

- ✓ Боловсрол судлал
- ✓ Үндэстний цөөнхийн хэл, соёл, түүх, боловсрол /Хос хэлний боловсрол/

Хаяг: Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 11-р баг, А.Жамила-1 гудамж, 123 тоот

Холбоо барих утас: +70422582, 99183724



МУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын байршил

НОМЫН САН

МУБИС нь МБУС, Архангайн Багшийн Сургуулийн номын сан, Баян-Өлгийн Багшийн Сургуулийн номын сан, СӨБС, БС МУБИС-ийн харьяа ЕБС, Төв номын сан гэсэн салбар нэгжүүдэд үйл ажиллагаагаа явуулж байна. Номын сан нь 268610 ширхэг сан хөмрөгтэй, танхимын болон чөлөөт сонголтын үйлчилгээг хүргэж байна. Номын сан нь олон улсын стандартад нийцсэн программ хангамж MARC21 стандарт, Z39.50 протоколыг дэмжсэн Коха программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн уншигчдад үйлчилгээ үзүүлж байна.

Онлайн каталогийн хаяг:

1. <http://catalog.msue.edu.mn>
2. <http://library.msue.edu.mn/>

Оюутан номын сангаар үйлчлүүлэх:

МУБИС-ийн оюутан та МУБИС-ийн номын сангийн аль ч салбар нэгжээр үйлчлүүлэх эрхтэй. МУБИС-ийн номын сан нь багш, оюутан, магистрант, докторант, орой, эчнээ, шаталсан зэрэг бүх хэлбэрээр суралцаж буй оюутнуудад үйлчилдэг. Суралцагч МУБИС-ийн номын сангаар үйлчлүүлэхийн тулд тухайн үйлчлүүлэх хэсэгт очоод өөрийн оюутны веб-дээ нэвтрэн хувийн QR кодоо номын сангийн QR код унших төхөөрөмжид уншуулж мэдээллээ тулган үйлчилгээгээ авна. Оюутан та вебдээ хувийн мэдээллээ бүрэн оруулж өөрийн зургаа заавал оруулсан байх шаардлагатай.

МУБИС-ийн номын сангийн цахим үйлчилгээ


Уншигч та доорх QR кодыг ашиглан манай номын сангийн цахим үйлчилгээтэй танилцарай.



Iphone утаснаас шууд уншина, Android бол QR scanner татаж суулгах шаардлагатай

№	Танхим	Үйл ажиллагааны чиглэл	Суудлын тоо	Байршил
1	Судалгааны танхим-1	Түүх нийгмийн ухааны боловсрол	80	Төв номын сан 2 давхарт
2	Судалгааны танхим-2	Монгол хэл, уран зохиол, хэл шинжлэлийн боловсрол	80	Төв номын сан 3 давхарт
3	Судалгааны танхим-3	Эрдэм шинжилгээний танхим	20	Төв номын сан 3 давхарт
4	Судалгааны танхим-4	Боловсрол судлал, сэтгэл судлалын боловсрол	80	Төв номын сан 4 давхарт
5	Тогтмол хэвлэл	Сонин, сэтгүүлийн танхим	10	Төв номын сан 4 давхарт
6	Гэрээр ном олгох танхим	Бүх төрлийн шинжлэх ухааны ном		Төв номын сан 2 давхарт
7	МБУС.БТС-ийн номын сан	Математик байгаллийн ухааны боловсрол	200	МБУС,БТС -ийн сургууль
8		Биений тампын боловсрол		
9	Багшийн сургуулийн номын сан	Бага ангийн багшийн боловсрол	90	Багшийн сургууль
10	СӨБС-ийн номын сан	Сургуулийн өмнөх боловсрол	100	СӨБС
11	Архангай багшийн сургуулийн номын сан	Бүх төрлийн шинжлэх ухааны ном	150	Архангай аймаг
12	ЕБС-ийн номын сан	Ерөнхий боловсрол		ЕБС

МУБИС-ийн Төв болон салбар номын сангууд байршил:



№	Номын сангууд	Байршил
1	Төв номын сан	Хичээлийн 12 -р байр
2	Багшийн сургуулийн номын сан	Хичээлийн 6-р байрны өргөтгөл
3	МБУС, БТС-ийн номын сан	Хичээлийн 3-р байр
4	СӨБС-ийн номын сан	4-р хороолол модны 2-ийн автобусны буудлын баруун урд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн 7-р төвийн баруун урд талд 4 давхар шар барилга (Хичээлийн 8-р байр)

ДОТУУР БАЙР

МУБИС-ийн оюутан нь оюутны дотуур байранд орох хүсэлтээ хичээлийн жилийн эхэнд оюутны веб (<http://student.msue.edu.mn>)-ийн ДОТУУР БАЙР цэс рүү орж хүсэлт гаргана. Хүсэлт хүлээн авч байранд орох эрх олгоно.

Дараах бичиг баримтыг бүрдүүлж дотуур байранд суух гэрээ хийнэ. Үүнд:

1. Бүрэлдэхүүний сургуулиас олгосон зөвшөөрлийн хуудас
2. Шинжилгээний бичиг / сүрьеэ, дох, цагаан хорхой, арьс өнгө.. г.м /

Оюутны дотуур байр			
1	Оюутны өргөө I	Бүх сургуулийн дотоод гадаадын оюутнууд хүсэлтээр	Баянзүрх дүүргийн 6-р хороо, Арслантай гүүрний урд, оюутны 2-р байртай залгаа 9 давхар байр
2	Оюутны өргөө II	Бүх сургуулийн дотоод гадаадын оюутнууд хүсэлтээр	Баянзүрх дүүргийн 6-р хороо, Арслантай гүүрний урд, оюуны ундраагийн зүүн талаар урагш эргэмэгц урд нь байрлах 9 давхар байр
3	1-р байр	МУБИС-ийн оюутнууд	Баянзүрх дүүргийн 6-р хороо, Арслантай гүүрний урд Оюутны өргөө II-ын залгаа з.х улаан дээвэртэй хөндлөн
4	2-р байр	МУБИС-ийн оюутнууд	Баянзүрх дүүргийн 6-р хороо, Арслантай гүүрний урд Оюутны өргөө II-ын арк гармагц зүүн талд ногоон хүрэн
5	3-р байр	Багш, ажилчид	Баянзүрх дүүргийн 6-р хороо, Арслантай гүүрний урд Оюутны өргөө I-ын зүүн урагш шороон замын зүүн урд баруун тийш харсан 4 давхар ногоон алаг байр
6	4-р байр	МУБИС-ийн оюутнууд	Баянзүрх дүүргийн 8-р хороо, Арслантай гүүрний хойно БоСС-ийн ард залгаа 4 давхар шар байр
7	5-р байр	МУБИС-ийн гадаад оюутнууд	Баянзүрх дүүргийн 8-р хороо, Сонор плазагаас хойш зам дагуу МУИС-ийн хичээлийн 4-р байрны урд залгаа ногоон саарал 4 давхар



Бүлэг I

Бүлэг II

Бүлэг III

Бүлэг IV

Бүлэг V

Бүлэг VI

БҮЛЭГ II. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 33

Сургалтын нэр, томъёоны тайлбар:	33
Ахисан түвшний сургалтын зохион байгуулалт:	34
МУБИС-ийн Сургалтын удирдлага мэдээллийн систем	34
“OFFICE 365” онлайн программ	39

БҮЛЭГ III. МАГИСТРЫН СУРГАЛТ 41

1. Элсэлт, бүртгэл	42
Бүртгүүлэгчдэд тавих шаардлага:	42
Бүрдүүлэх бичиг баримт:	42
Элсэлтийг баталгаажуулах:	43
2. Суралцах үйл явц	44
Суралцах хугацаа:	44
Сургалтын төлөвлөгөө:	44
Хичээл сонголт:	46
Сургалтын төлбөр	47
Гадаад хэлний шалгалт	47
Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө	47
3. Төгсөх үйл явц	48
Магистрын ажил:	48
Магистрын ажлын урьдчилсан хамгаалалт:	48
Магистрын ажлын жинхэнэ хамгаалалт:	48
Магистрын ажил хүлээлгэж өгөх	49
Магистрын зэрэг олгох, төгсөлт	49

БҮЛЭГ II. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сургалтын нэр, томъёоны тайлбар:

Сургалтын төлөвлөгөө (Learning Plan) гэдэг нь дээд боловсролын сургалтын зохион байгуулалт, судлах хичээл болон дадлага, тэдгээрийн кредит цагийг тусгасан баримт бичиг юм.

Хичээлийн хөтөлбөр (Course Curriculum) гэдэг нь сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээл бүрээр оюутны эзэмшвэл зохих онол, практикийн мэдлэг, чадварын агуулга, тухайн хичээлийн багтаамж, хичээлийн явцын ерөнхий төлөвлөлт, үнэлгээ, ашиглавал зохих ном сурах бичгийн жагсаалт зэргийг тодорхой тусгасан байна. Хичээлийн хөтөлбөр нь хүрэх үр дүн, агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ зэргийг тусгасан сургалтын баримт бичиг байна.

Хичээлийн кредит (Course Credit) гэдэг нь хичээлийн агуулгыг илэрхийлэх бүхэл тоо байх бөгөөд хэмжээ нь долоо хоногт тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамаарна. Оюутны сурах үйл ажиллагаанд нэг долоо хоногт зарцуулах дараах багц бүрийг нэг кредит цаг гэж тодорхойлно. Үүнд:

- 16 цагийн лекц + долоо хоног бүр бие даан гүйцэтгэх ажлын 2 цаг;
- 32 цагийн семинар + долоо хоног бүр бие даан гүйцэтгэх ажлын 1-2 цаг;
- 32 цагийн лаборатори+ долоо хоног бүр бие даан гүйцэтгэх ажлын 1-2 цаг;
- 32 цагийн практик+ долоо хоног бүр бие даан гүйцэтгэх ажлын 1-2 цаг;

Жишээлбэл, долоо хоног бүр 1 кредитэд 2 цаг; 2 кредитэд 3 цаг, 3-4 кредитэд 5 цагийн бие даан гүйцэтгэх ажлын цагийг тус тус төлөвлөн хэрэгжүүлнэ. Кредитийн задаргааг томъёолохдоо тухайлбал: 3 кредит нь 2:2:0:0 (5) байна. Үүнийг долоо хоног бүр лекц 2 цаг, семинар 2 цаг, лаборатори, практик тус бүр 0 цаг, бие даан гүйцэтгэх ажил 5 цаг байна гэж ойлгоно. Дадлага, бакалаврын төгсөлтийн ажилд оюутны зарцуулж буй 32 цагийг нэг кредиттэй дүйцүүлж тооцно.

Хичээлийн 1 цаг нь 50 минут байх ба хоёр цагийн хичээл нь завсарлагагүйгээр 90 минут үргэлжилнэ.

Хичээлийн үнэлгээ (Course Assessment) гэдэг нь хичээлийн хүрэх үр дүн буюу оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхой шалгуураар үнэлэх ажиллагаа. Үнэлгээ нь "үсгэн үнэлгээ", "тоон үнэлгээ" гэсэн хэлбэртэй байна.

Голч дүн (GPA) гэдэг нь оюутны эзэмшсэн мэдлэг, чадварын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд судалсан хичээл бүрээр оюутны авсан оноог кредит цагаар үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг кредитийн нийлбэрт хуваасан (арифметикийн жигнэсэн дундаж) үзүүлэлт.

Цахим сургалт (e-learning) гэдэг нь интернэт сүлжээ, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалтын үйл ажиллагаа юм. Бүрэн цахим (online) болон хосолсон (blended) гэсэн хоёр хэлбэртэй байж болно.

- Бүрэн цахим буюу онлайн сургалт (online learning)- Онлайн сургалт нь сургалтын үйл ажиллагааг интернэт сүлжээтэй орчинд зайнаас суралцах буюу сургалтын удирдлага мэдээллийн системийн тусламжтайгаар зохион байгуулах үйл ажиллагааг хэлнэ.
- Хосолсон сургалт (Blended learning)- Сургалтын үйл ажиллагааг цахим технологиос гадна шаардлагатай үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахыг хэлнэ.

Сургалтын удирдлага мэдээллийн систем (СУМС) гэдэг нь сургалтын үйл ажиллагааг цахим технологиор зохион байгуулах иж бүрэн программын шийдэл юм.

Ахисан түвшний сургалтын зохион байгуулалт:

Магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрийг “Ахисан түвшний хөтөлбөр” гэж нэрлэнэ. МУБИС-ийн ахисан түвшний сургалтын үйл ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ хийх ажлыг Ахисан түвшний хөтөлбөрийн алба хариуцдаг. Ахисан түвшний хөтөлбөрийн алба нь ахисан түвшний сургалтын бүртгэл, элсэлт, хичээлийн хуваарь гаргах, үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөн туслах, уялдаа холбоог хангах, сургалтын зохион байгуулалт, хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилладаг. Ахисан түвшний сургалтын зохион байгуулалт нь:

- Танхимын
- Цахим
- Хосолсон гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байна.

Суралцагчийн тоо 1-4 бол сургалтыг цахим болон хосолсон хэлбэрээр, 5 буюу түүнээс дээш бол танхимаар зохион байгуулна. Цахим болон хосолсон хэлбэрээр сургалт зохион байгуулахад сургалт удирдлага мэдээллийн системийг ашиглана.

МУБИС-ийн Сургалтын удирдлага мэдээллийн систем

МУБИС-ийн сургалт удирдлага мэдээллийн системд нэвтрэхийн тулд <https://ulms.msue.edu.mn/> холбоосыг ашиглана. Үүний дараа гарч ирсэн нэвтрэх цонхонд сургуулийн хөтөлбөрийн албанаас өгсөн нэвтрэх нэр, нууц үгийг оруулна.

Үндсэн нүүр хуудас: СУМС-д нэвтрэн ороход үндсэн нүүр хуудас харагдах ба цонхны баруун гар талд цэсүүд байршина.




Үндсэн цэс

Нүүр хуудас: Суралцагчийн ерөнхий мэдээлэл болон сургуулиас сүүлд нийтэлсэн мэдээ, мэдээллүүд харагдана. Ерөнхий мэдээлэл хэсгээс оюутан өөрийн gmail хаяг, түүний нууц үг, office 365 э-мэйл хаяг, түүний нууц үг зэрэг мэдээллийг авах боломжтой. Сургалт онлайн болон хосолсон сургалтаар зохион байгуулагдах болсон үед МУБИС нь office 365-ийн онлайн сургалтын teams программыг ашигладаг учраас teams программд шууд нэвтрэх боломжтой холбоосыг мөн оруулж өгсөн байна.

Хичээл сонголт

Хичээл сонголт: Хичээл сонголт нээгдсэн үед СУМС-д нэвтрэн орж хичээл сонголт хэсгээс сонголтоо хийнэ. Хичээлүүдийн жагсаалтаас тухайн улиралд өөрийн үзэх хичээлүүдийг сонгоод хамгийн доор байрлах “сонгох” гэсэн товч дээр дарна.



Үүний дараа дээд хэсэгт сонгосон хичээлийн тоо, нийт кредит, сургалтын төлбөрийн мэдээлэл гарч ирнэ. Сонгосон хичээлүүдийг “түр сануулах” товч дээр дарж хадгална. Хэрэв буруу хичээл сонгосон бол засах боломжтой. Харин “баталгаажуулах” товч дээр дарснаар таны сонголт хөтөлбөрийн албад илгээгдэх ба та сонголт хийсэн хичээлийг засах боломжгүй болно.

СОНГОСОН ХИЧЭЭЛЛҮД

Нийт хичээлийн тоо: 6
Нийт кредит: 13
Нийт төлбөр: 1166000

Ерөнхий сурвалж - Засах

№	Төвлөл	Хичээлийн нэр	Хичээлийн явц	Кредит	Өмнөх хичээл	Цэг	Төлбөр
1	S.IT101	Мэдээлэл технологийн системийн үндэс	2.00	1	180000		
2	S.IT101	Философи	3.00	0	250000		

Сонгох сурвалж - Засах

№	Төвлөл	Хичээлийн нэр	Хичээлийн явц	Кредит	Өмнөх хичээл	Цэг	Төлбөр
1	S.SS112	Бүтэцмэл судалгаа	2.00	0	170000		
2	S.SS112	Англи хэл	3.00	0	280000		

Мэдээлэл - Засах

№	Төвлөл	Хичээлийн нэр	Хичээлийн явц	Кредит	Өмнөх хичээл	Цэг	Төлбөр
1	A.SS127	Төвлөл ажилын дараах	1.00	0	95000		

Сургалт

Одоо судалж буй хичээл: Хичээлийн хуваарь, Хичээлийн явц гэсэн хоёр хэсэгтэй. Хичээлийн хуваарь хэсгээс тухайн улиралд сонгосон хичээлүүдээр хичээлийн хуваарь зохиогдон харагдах ба хэвлэж авах боломжтой. Хичээлийн явц хэсгээс хичээл тус бүрээр өөрийн суралцаж буй явцаа хянах боломжтой.

Дүнгийн мэдээлэл: Нийт судалж дууссан хичээлүүдийн дүнг харна. Мөн “дүнгийн тодорхойлолт авах” гэсэн дээр дарж дүнгийн тодорхойлолт оо хэвлэж авах боломжтой.

Төлбөрийн мэдээлэл: Сургалтын төлбөр, Дотуур байр, Торгууль, Ромбо диплом гэсэн дөрвөн хэсэгтэй. Сургалцагчийн төлөх төлбөрийн мэдээллүүдийг харуулна.

№	Улирал	Сонгосон кредит	Төлбөр зохих	Зэм, тусламж	Татгалз	Цэвэрл	Нийт төлбөр	Төлбөр дүн
1	2023-2024 намар	19	1370980	0	0	0	1370390	70
2	2023-2024 намар	11	1044000	0	0	99009	99300	70
			26	2414409	0	0	99009	2324063
			Түдэлдэг: 0					

Цахим хичээл: Судалж буй цахим хичээлүүдийн нэр, мэдээлэл харагдана.

Цахим сорил: Хичээлүүдийн цахим сорилуудын мэдээлэл харагдана. Цахим сорил нь тодорхой хугацаанд нээгдээд, хаагдах буюу оролцох боломжгүй болох учраас суралцагчид “идэвхтэй хугацаа” баганыг анхаарч, багшийн зарласан хугацаанд сорилдоо оролцох хэрэгтэй.

Хүсэлт

Өргөдөл, хүсэлт: Сургуульд өргөдөл, хүсэлт, гаргах шаардлагатай үед СУМС-ээр дамжуулан хүсэлт гаргана. Хүсэлтийн төрлийг сонгоод, шалтгаан хэсэгт хүсэлт гаргаж буй шалтгаанаа бичээд утасны дугаар хэсэгт холбогдох утасны дугаарыг оруулж “илгээх” товчийг дарна.

Тодорхойлолт

Анкет: СУМС-д таны оруулсан мэдээлэл харагдана. Мөн өөрийн мэдээллийг “засах” товч дээр дараад шинэчлэн оруулж болно. “Анкет хэвлэх” товч дээр дарж өөрийн мэдээлэл бүхий анкетыг хэвлэн авч болно.

Тодорхойлолт: Сурдаг нь үнэн, Дүнгийн тодорхойлолт гэсэн хоёр тодорхойлолтуудыг монгол эсвэл англи хэлээр авч болно.

Нэмэлт

Дүрэм журам: МУБИС-ийн дүрэм журмыг байршдаг.

Тэтгэлэг зээл тусламж: Тэтгэлэг болон зээл тусламжтай холбоотой мэдээ, мэдээлэл байршдаг.

Гарын авлага: МУБИС-ийн оюуны гарын авлагууд байршдаг.

Судалгаа

Судалгаа: МУБИС-ийн зүгээс авч буй төрөл бүрийн судалгаа байршдаг.

“OFFICE 365” онлайн программ

Office 365 гэдэг нь бидний өдөр тутам хэрэглэдэг оффисын программуудыг бусад хэрэгцээт программуудтай багцалж нэгдсэн байдлаар санал болгож буй үүлэн шийдэл юм. Бүх төрлийн төхөөрөмжөөс, хэзээ ч, хаанаас ч ашиглах боломжтой. Таны файлыг онлайнд найдвартай хадгалснаар та хүссэн үедээ өөрийн хийж байгаа зүйлээ хамгийн сүүлийн үеийн Microsoft Office -ийн A1 лиценз дэх бүх төрлийн программ хангамж дээр хийж гүйцэтгэх юм.


МУБИС-ийн оюутан бүр “OFFICE 365” онлайн программыг суралцах хугацаандаа үнэ төлбөргүй ашиглана. Сургуулийн зүгээс 365 э-мэйл хаягийг нээж, office 365 э-мэйл хаяг болон нууц үгийг СУМС-ийн ерөнхий мэдээлэл хэсэгт байршуулсан байдаг.

Суралцагч СУМС-ийн нүүр хуудасны ерөнхий мэдээлэл хэсэгт байрлах /Teams нэвтрэх бол энд дарна уу/ гэсэн холбоос дээр дарж, гарч ирэх цонхонд office 365 э-мэйл хаяг, нууц үгийг оруулснаар office 365 онлайн программыг ашиглах боломжтой болно.

Office 365 онлайн программ ашиглан:

- Онлайн word, excel, powerpoint, teams, outlook зэрэг олон төрлийн ашгуудыг хэрэглэх боломжтой
- Үүлэн дээр 1 терабайт (1024 гигабайт) хүртэл файл хадгалах
- Teams ашиглан онлайн болон хосолсон хэлбэрээр зохион байгуулагдаж буй хичээлд оролцох
- Багш болон бусад оюутнуудтайгаа харилцах

- Сургуулийн зүгээс хүргэх үйлчилгээ болон мэдээллийг түргэн шуурхай, цаг алдалгүй хүлээн авах гэх мэт олон төрлийн боломжтой.



БҮЛЭГ III. МАГИСТРЫН СУРГАЛТ

1. Элсэлт, бүртгэл

МУБИС-ийн магистрын зэрэг олгох сургалтад хамрагдах суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь МУБИС-ийн элсэлтийн нэгдсэн систем (<http://burtgel.msue.edu.mn/>) хаягаар цахим хэлбэрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ. Элсэлтийн үйл ажиллагаа нь ахисан түвшний сургалтын хувьд жилд гурван удаа 9, 11, 4 саруудад зохион байгуулна. Бичиг баримт дутуу, өөр агуулгатай бичиг баримт бүрдүүлэх, холбоо барих хаяг тодорхойгүй байх тохиолдолд элсүүлэх боломжгүй болно.

Бүртгүүлэгчдэд тавих шаардлага:

- 1) Бүртгүүлэгч нь Монгол улсын харьяат бус иргэн байх бөгөөд хууль эрх зүйн хувьд өөрийгөө бүрэн хариуцах чадамжтай байна.
- 2) Бүртгүүлэгч нь Монгол хэлний зохих түвшний шаардлага хангасан, монгол хэл, бичгийн шалгалтын 70 онооноос дээш байна. МУБИС-ийн болон Монголын их, дээд сургуульд бакалаврын түвшинд суралцаж төгссөн бол шалгалтаас чөлөөлнө. 70-аас доош оноо авсан тохиолдолд Монгол хэл, бичгийн бэлтгэл ангид хэлний түвшнээс шалтгаалан 6-18 сар хэлний бэлтгэлд суралцана.
- 3) Бүртгүүлэгч нь бакалаврын зэрэгтэй байна.

Бүрдүүлэх бичиг баримт:

Дээрх шаардлагыг хангасан бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Гадаад паспортын хуулбар /Паспортын нүүрэн хэсгийг дэлгэмэл байдлаар сканердсан хуулбар, хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх/
- Эрүүл мэндийн хуудас
- Иргэний үнэмлэх /биеийн байцаалт/-ийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын зэргийн дипломын хуулбар
- Бакалаврын зэргийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбар
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудас

- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудасны монгол хэл дээр баталгаат орчуулга
- Төгсөлтийг гэрчлэх QR код бүхий тодорхойлолт /монгол хэл дээр баталгаат орчуулгын хамт/
- 3*4 хэмжээтэй зураг 4 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт /Хаан банк, МУБИС-ийн захиргаа аж ахуй, Данс: 5031749242, Гүйлгээний утга: Паспорт дээрх нэр, паспортын дугаар/
- Гадаад элсэгчийн магистрантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 120.000 төгрөг байна.
- Гадаад оюутнаас авах Монгол хэл, бичгийн шалгалтын хураамж 50.000 төгрөг байна

Элсэлтийг баталгаажуулах:

- Магистрантыг элсүүлсэн тухай бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалыг үндэслэн МУБИС-ийн захирал нэгдсэн тушаал гаргана.
- МУБИС-д элсэх эрх авсан, захирлын тушаалаар баталгаажуулсан суралцагчийг МУБИС-ийн “Магистрант” гэх ба тэр цагаас МУБИС-ийн оюутны суралцах гэрээг байгуулж, магистрант болохыг гэрчлэх оюутны үнэмлэх, оюутанд үйлчлэх карт зэргийг бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанаас олгоно.

Жич: *Шинээр элссэн болон шилжин суралцаж буй суралцагчийн өмнөх боловсрол нь (бакалаврын мэргэжил нь МУБИС-т суралцах гэж буй магистрын мэргэжлээс) өөр бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангах үүднээс нэмж хичээл сонгон суралцах ба энэ хичээл нь 6 кредитээс багагүй байна.*

2. Суралцах үйл явц

Суралцах хугацаа:

Магистрын хөтөлбөрийн үндсэн хугацаа 3 улирал байх бөгөөд магистрантын сонгосон кредитээс шалтгаалан үүнээс олон байж болно. МУБИС-ийн ахисан түвшний сургалт намар, хавар, өвөл+зун гэсэн 3 үндсэн улиралтай байх бөгөөд суралцагч жилд 2-оос илүү улиралд хичээл сонгон судлах боломжгүй. Нэг улирлын үргэлжлэх хугацаа 16 долоо хоног байх бөгөөд үүнд, үндсэн сургалт, бие даан суралцах, судалгааны ажил, семинар, хэлэлцүүлэг зэрэг багтана.

Сургалтын төлөвлөгөө:

Бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба нь хариуцсан сургалтын төлөвлөгөө, тухайн улиралд судлах хичээлийн хөтөлбөр, багшийн мэдээллийг хичээл сонголт эхлэхээс өмнө мэдээллийн системд байршуулж, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтэн, оюутанд үйлчлэх ажилтан хамтран, суралцагчдад шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгдөг. Иймээс суралцагч магистрант нь өөрийн суралцах магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөтэй нэг бүрчлэн танилцаж, хичээл сонголт хийх, судалгааны ажил бичих гэх мэт өөрийн суралцах үйл явцыг нарийвчлан төлөвлөх шаардлагатай.

Магистрын сургалтын төлөвлөгөө нь 30 кредитээс багагүй хэмжээтэй, дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Мэргэжлийн суурь хичээл 10 кредит
- Мэргэшүүлэх хичээл 12 кредитээс доошгүй
- Судалгааны ажил (судалгааны семинар, дипломын ажил) 8 кредит.

Суралцагч нь сургалтын төлөвлөгөөний хичээлийг бүрэн судалснаар магистрын дипломын ажил бичиж хамгаалах эрхтэй болно. Сургалтын кредит цагаа бүрэн судалсан суралцагчид МУБИС-ийн магистрын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаалаар гэрчилгээ олгоно. Суралцагч нь тухайн хөтөлбөрийн хүчинтэй хугацаанд үргэлжлүүлэн суралцаж судалгааны кредитээ гүйцээн магистрын ажил бичиж хамгаална. Магистрант нь магистрын дипломын ажил бичихгүй тохиолдолд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлээс 10 кредит сонгон судална.

Ахисан түвшний сургалтын төлөвлөгөөний хичээл, эрдэм шинжилгээний ажлын багтаамж нь дараах бүтэц, агуулгын чиглэлтэй байна.

№	Агуулгын бүтэц	Агуулгын чиглэл
1	Мэргэжлийн суурь хичээл	Судалгааны чиглэлтэй холбоотой мэдээлэл эрж хайх, тоо баримт цуглуулах, ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж судлах, мэдээллийг боловсруулах, загварчлах, судалгааны программаар боловсруулалт хийх, тооцоолох, туршилт хийх, судалгааны ажлаа тайлагнаж, илтгэл тавих, өгүүлэл бичиж сурахад чиглэнэ.
2	Мэргэшүүлэх хичээл	Мэргэшүүлэх хичээл нь нарийн мэргэжлээр судлаачийн эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна. Удирдагч багшийн удирдлагаар бие даан судалж илтгэх, хичээлийн агуулгын зарим хэсгийг мэргэжлийн семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж реферат бичих, тохиолдлын судалгаа (case study) хийх, шалгалт өгөх хэлбэрээр кредит тооцуулахыг зөвшөөрнө. Магистрант нь суралцаж буй чиглэлээрээ 3 кредит хичээлийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгон судалж болно. Энэ нь мэргэшүүлэх хичээлийн кредитэд багтана.
3	Судалгааны ажил	Онолын ба судалгааны семинарыг удирдагч багшийн удирдлагаар магистрант 3 кредит (1 кр судалгааны төсөлт ажлын, 2 кр судалгааны семинар) кредит цаг судална. Магистрын ажил 5 кредит байна. Магистрантын судалгааны ажлын 5 кредитийг бичсэн дипломын ажлыг хамгаалуулах зөвлөл, удирдагч багш шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд тооцно.

Судалгааны төсөлт ажлын, судалгааны болон онолын семинарыг албан ёсны удирдагч багш удирдах бөгөөд суралцагч дараах ажлуудыг хийж гүйцэтгэн кредит тооцуулна.

Үүнд:

- Эрдэм шинжилгээний их семинарт хамрагдсан бол 0.5 кр;
- Судалгааны ажлаа тэнхимийн болон бусад их семинарт хэлэлцүүлсэн бол 1 кр;
- Их дээд болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 1.5 кр;
- Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 2 кр;
- Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 3 кр;
- МУБИС-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 2 кр, мэргэжлийн түвшинд хянагддаг гадаад хэл дээр хэвлэгддэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 3 кр;
- Удирдагч багшийн хэрэгжүүлж буй МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөлд оролцсон бол 1 кр, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй дотоодын төсөлд оролцсон бол 2 кр, гадаадын санхүүжилттэй төсөлд оролцсон бол 3 кр;

- Сэдвийнхээ хүрээнд Web of Science болон Scopus-ийн индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 6 кр;

Хичээл сонголт:

Хичээл сонголтыг сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандарт, тодорхойлолтыг үндэслэн хийнэ. Ингэхдээ тэнхим, хөтөлбөрийн албаны мэргэжилтний зөвлөмжийн дагуу, хичээл сонгох, цуцлах, баталгаажуулах үйл ажиллагааг хийнэ.

Хичээл сонголтыг 2 үе шаттайгаар цахим хэлбэрээр хийнэ. Тухайн улиралд судлах хичээлийг "Сонголт-1"-ээр, хичээл заах багш, хичээллэх өдөр, цагийг "Сонголт-2"- оор баталгаажуулна. Суралцагч Сонголт 1, 2-ыг тухайн улирлын "0" долоо хоногт цахимаар хийж, хичээлийн хуваарийг хэвлэн гарын үсгээ зурж баталгаажуулан хариуцсан хөтөлбөрийн албаны мэргэжилтэнд өгнө. Суралцагч нэг улиралд 15 хүртэл кредит судлах ба үүнд судалгааны ажлын кредит хамаарахгүй. Нэг улиралд судлах кредитийн доод хэмжээ 10 кредит байна. Хичээл сонгож баталгаажуулаагүй суралцагчийг хичээлд суулгахгүй.

Суралцагч бусад их сургуулиас хичээл судлах үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу төрийн өмчийн бусад их сургуулиас хичээл сонгон судалж болно. Үүнд:

- Өөрийн хөтөлбөрт багтсан тодорхой хичээлийг дүйцүүлэх;
- Өөрийн хөтөлбөрийн чөлөөт сонголтын, эсвэл бусад нэгжээс судлахаар тодорхойлсон хичээлийн нэр заагаагүй багцын биелэлтэд тооцуулах;
- Өөрийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт хичээл сонгох;

Багцад тооцуулах зорилгоор бусад сургуулийн ижил түвшний хөтөлбөрийн хичээл солилцооны системд бүртгэлтэй хичээлээс сонгон судалж болно. Суралцагч өөрийн сонирхлоор бусад сургуулиас нэмэлт хичээл сонгон судлах тохиолдолд уг хичээлийг суралцаж буй хөтөлбөрийн кредит цагийн биелэлтэд тооцохгүй.

Суралцагч тухайн улиралд судлах хичээлээ сонгож, сургалтын төлбөр төлснөөр сурах эрхтэй болно.

Сургалтын төлбөр

1. Сургалтын төлбөрийг судлах хичээлийн кредитийн үнэлгээгээр тогтооно.
2. Суралцагч нь сургалтын төлбөрийг хичээл "Сонголт-2"-ыг хийхээс өмнө төлсөн байна.
3. Суралцагч нь тодорхой байгууллага, хувь хүний тэтгэлэг, зээлд хамрагдан сургалтын төлбөрөө төлж болно.

4. Суралцагч нь МУБИС-ийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах тохиолдолд магистрын төгсөлтийн ажлын 5 кредитэд сургалтын төлбөрийн аливаа хөнгөлөлт тооцохгүй.

Гадаад хэлний шалгалт

Магистрант нь сургалтын төлөвлөгөөний хичээлийн 20 кредит цагийг судалсны дараа гадаад хэлний шалгалт өгнө. Гадаадын суралцагч нь гадаад хэлний шалгалтыг ToPМON (Монгол хэлний түвшинг тогтоох сорил) өгч дундаас дээш оноотой бол тооцуулж болно. Гадаад хэлний шалгалтад хангалттай дүн авч чадаагүй суралцагч магистрын ажлын хамгаалалтад орох эрхгүй болох ба төлбөртэйгөөр дараагийн улиралд дахин шалгалт өгч болно.

Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө

Бүрэлдэхүүний сургууль нь мэргэжлийн тэнхим, профессор багш, суралцагчийн саналд тулгуурлан суралцагч нэг бүрээр судалгааны ажлын сэдэв, удирдагчийн нэрийг гаргаж, МУБИС-ийн захирлын тушаалаар улиралд 1 удаа баталгаажуулна.

Удирдагч багшийн үүрэг:

- Удирдагч нь магистрантын судалгааны ажлын сэдэв, төлөвлөгөөг чиглүүлэн тогтоож, гүйцэтгэлийг нь хянаж, туршилт хийх, үр дүнг боловсруулах, задлан шинжлэх, өгүүлэл бичих, илтгэл тавих зэрэг үйл ажиллагааг удирдан чиглүүлж, магистрын сургалт судалгааны семинарыг тогтмол зохион байгуулна.
- Удирдагч нь магистрын ажил бичихэд зөвлөн тусалж, агуулга, чанар, судалгааны ажлын үр дүнгийн шинжлэх ухааны бодитой байдал, хууль эрх зүйн хүрээнд хийсэн эсэхийг хянадаг байна.

Магистрантын эрх, үүрэг:

- Суралцагч нь магистрын ажлын сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшилцөн боловсруулж, тэнхимийн эрхлэгчээр хянуулан хөтөлбөрийн албаны даргаар баталгаажуулсан байна.
- Магистрант нь судалгааны ажлаа тодорхой төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж тайлагнах бөгөөд удирдагч нь зөвлөн тусалж, хянаж чиглүүлэн - тэмдэглэл хөтөлнө.
- Магистрант нь удирдагч болон судалгааны ажлын сэдвээ өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүний сургуулийн саналыг үндэслэн МУБИС-ийн захирал тушаал гаргаж шийдвэрлэнэ.

3. Төгсөх үйл явц

Магистрын ажил:

Магистрын ажил нь шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судалж, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээг онол, арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, судалгааны үр дүнг тодорхой үзэл баримтлалд үндэслэн нотлох, асуудлыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн санал, дүгнэлт, зөвлөмж бүхий судалгааны ажил байна.

Магистрын ажил нь төсөл, эсвэл нэг сэдэвт бүтээл байж болох ба энэ тохиолдолд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, хэрэгжүүлэх арга зам, хүлээгдэж буй үр дүнг тодорхой томъёолж, туршилт судалгаа хийсэн байна.

Магистрын дипломын ажлыг МУБИС-ийн захирлын тушаалаар баталсан стандартын дагуу техникийн, арга зүйн болон академик бичиглэлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Магистрын ажлын урьдчилсан хамгаалалт:

- a. Магистрын дипломын ажлын урьдчилсан хамгаалалтыг тэнхим (профессорын баг)-ийн өргөтгөсөн их семинараар хийнэ. Их семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийж болно. Өргөтгөсөн их семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколын хамт хамгаалуулах зөвлөлд хүргүүлнэ.

Магистрын ажлын жинхэнэ хамгаалалт:

- b. Магистрант нь сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийг бүрэн судалж зохих кредитийг цуглуулсан, гадаад хэлний шалгалтыг амжилттай өгсөн, сургалтын төлбөрийг бүрэн төлсөн, судалгааны ажлаа тэнхимээр урьдчилан хэлэлцүүлсэн, бүтээлийн хуулбарлалтыг шалгах программаар уншуулж зохих шаардлага хангасан зэргийг үндэслэн хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга магистрантын судалгааны ажлыг хамгаалуулах хүсэлтийг зөвлөлд уламжилна.
- c. Магистрын зэрэг горилсон бүтээлийг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцэж хамгаална. Хамгаалуулах зөвлөлийн хуралдаан жилд 2 удаа болох ба тухай бүрд тэнцсэн эсэх (75 хувиас доошгүй) талаар тогтоол гаргана.

- д. Магистрын ажлаа хамгаалж чадаагүй бол 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтад орох хүсэлтээ магистрант хамгаалуулах зөвлөлд гаргана.

Магистрын ажил хүлээлгэж өгөх

Хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь амжилттай хамгаалсан магистрын дараах материалыг бүрдүүлэн МУБИС-д ирүүлнэ. Эдгээр материалыг дипломын хуулбарын хамт сургуулийн архив болон номын санд хадгална. Үүнд:

- а) Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
- б) Хамгаалуулах зөвлөлийн хурлын протокол, тогтоол
- в) Удирдагчийн тодорхойлолт
- г) Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертац, түүний CD бичлэг 1 хувь
- д) Тооцоо хийсэн тойрох хуудас зэрэг орно.

Магистрын зэрэг олгох, төгсөлт

- Магистрын ажлыг амжилттай хамгаалсныг баталсан хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, МУБИС-ийн захирлын тушаалаар магистрын зэрэг олгох шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг үндэслэн МУБИС магистрын зэргийн дипломыг дүрэм журмын хүрээнд хэвлэн баталгаажуулж, гардуулах ажлыг зохион байгуулна.
- Магистрын зэрэг олгох төгсөлтийг хичээлийн жилд хоёр удаа 1, 6-р сард хийнэ.

БҮЛЭГ IV. ДОКТОРЫН СУРГАЛТ 50

1. Элсэлт, бүртгэл 51
 - Бүртгүүлэгчдэд тавих шаардлага: 51
 - Бүрдүүлэх бичиг баримт: 51
 - Элсэлтийг баталгаажуулах: 52
2. Суралцах үйл явц 53
 - Суралцах хугацаа: 53
 - Сургалтын төлөвлөгөө: 53
 - Хичээл сонголт: 55
 - Сургалтын төлбөр 55
 - Гадаад хэлний шалгалт: 56
 - Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө: 56
3. Төгсөх үйл явц 57
 - Докторын диссертац: 57
 - Докторын диссертац урьдчилсан хамгаалалт: 57
 - Докторын диссертац хуулбарлалт шалгах: 57
 - Докторын диссертац жинхэнэ хамгаалалт: 58
 - Докторын диссертац хүлээлгэж өгөх 58
 - Докторын зэрэг олгох, төгсөлт 58

БҮЛЭГ V. МУБИС-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ 59

- Мэдлэг, чадварыг үнэлж, дүгнэх: 59
- Чөлөө авах: 61
- Сургуулиас чөлөөлөх: 61
- Шилжилт, хөдөлгөөн: 61
- Магистрант, докторант туслах ажилтнаар ажиллах: 62
- Сургуулиас олгох албан ба албан бус бичиг баримт 64

БҮЛЭГ VI. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ 66

- Улаанбаатар хот 66
- Гадаад оюутны визны мэдээлэл 68
- Гадаад оюутанд хэрэгтэй мэдээ, мэдээлэл 69
- Аюул тохиолдсон үед шаардлагатай дугаарууд: 71
- Ашигласан материал: 72

БҮЛЭГ IV. ДОКТОРЫН СУРГАЛТ

1. Элсэлт, бүртгэл

Боловсролын зэрэг олгох сургалтад хамрагдах суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь МУБИС-ийн элсэлтийн нэгдсэн систем (<http://burtgel.msue.edu.mn/>) хаягаар цахим хэлбэрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ. Элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэрэг олгох сургалтын хувьд жилд нэг удаа буюу 8 сард, ахисан түвшний сургалтын хувьд жилд гурван удаа 9, 12, 2 саруудад зохион байгуулна.

Бичиг баримт дутуу, өөр агуулгатай бичиг баримт бүрдүүлэх, холбоо барих хаяг тодорхойгүй байх тохиолдолд элсүүлэх боломжгүй.

Бүртгүүлэгчдэд тавих шаардлага:

1. Бүртгүүлэгч нь Монгол улсын харьяат бус иргэн байх бөгөөд хууль эрх зүйн хувьд өөрийгөө бүрэн хариуцах чадамжтай байна.
2. Бүртгүүлэгч нь Монгол хэлний зохих түвшний шаардлага хангасан, монгол хэл, бичгийн шалгалтын 70 онооноос дээш байна. МУБИС-ийн болон Монголын их, дээд сургуульд магистрын түвшинд суралцаж төгссөн бол шалгалтаас чөлөөлнө. 70-аас доош оноо авсан тохиолдолд Монгол хэл, бичгийн бэлтгэл ангид хэлний түвшнээс шалтгаалан 6-18 сар хэлний бэлтгэлд суралцана.
3. Бүртгүүлэгч нь бакалаврын болон магистрын зэрэгтэй байна.
4. Докторантурт элсэгч магистрын дипломын ажил бичээгүй төгссөн бол магистрын сургалтын төлөвлөгөөний судалгааны ажлын 8 кредитийг сонгон, судалгааны ажил бичиж магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн нийт гишүүдийн 75-аас доошгүй хувиар дэмжигдсэн байна.

Бүрдүүлэх бичиг баримт:

Дээрх шаардлагыг хангасан бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Гадаад паспортын хуулбар /Паспортын нүүрэн хэсгийг дэлгэмэл байдлаар сканердсан хуулбар, хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байх/
- Эрүүл мэндийн хуудас
- Иргэний үнэмлэх /биеийн байцаалт/-ийн хуулбар
- Иргэний үнэмлэхийн монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын зэргийн дипломын хуулбар
- Бакалаврын зэргийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга

- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбар
- Бакалаврын төгсөлтийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудас
- Бакалаврын дипломын цахим бүртгэлийн хуудасны монгол хэл дээр баталгаат орчуулга
- Магистрын зэргийн дипломын хуулбар
- Магистрын зэргийн дипломын хуулбарын монгол хэл дээр баталгаат орчуулга
- Магистрын дипломын цахим бүртгэлийн хуудас
- Магистрын дипломын цахим бүртгэлийн хуудасны орчуулга
- Сургууль төгссөн болохыг нотлох QR код бүхий тодорхойлолт монгол хэл дээр баталгаат орчуулгын хамт
- 3*4 хэмжээтэй зураг 4 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт /Хаан банк, МУБИС-ийн захиргаа аж ахуй, Данс: 5031749242, Гүйлгээний утга: Паспорт дээрх нэр, паспортын дугаар/
- Гадаад элсэгчийн магистрантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 120.000 төгрөг байна.
- Гадаад оюутнаас авах Монгол хэл, бичгийн шалгалтын хураамж 50.000 төгрөг байна

Элсэлтийг баталгаажуулах:

- Докторантыг элсүүлсэн тухай бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалыг үндэслэн МУБИС-ийн захирал нэгдсэн тушаал гаргана.
- МУБИС-д элсэх эрх авсан, захирлын тушаалаар баталгаажуулсан суралцагчийг МУБИС-ийн “Докторант” гэх ба тэр цагаас МУБИС-ийн оюутны суралцах гэрээг байгуулж, докторант болохыг гэрчлэх оюутны үнэмлэх, оюутанд үйлчлэх карт зэргийг бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанаас олгоно.

Жич: Шинээр элссэн болон шилжин суралцаж буй суралцагчийн өмнөх боловсрол нь (магистрын мэргэжил нь МУБИС-т суралцах гэж буй докторын мэргэжлээс) өөр бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангах үүднээс нэмж хичээл сонгон суралцах ба энэ хичээл нь 6 кредитээс багагүй байна.

2. Суралцах үйл явц

Суралцах хугацаа:

Докторын хөтөлбөрийн үндсэн хугацаа 6 улирал байх бөгөөд докторантын сонгосон кредитээс шалтгаалан үүнээс олон байж болно. МУБИС-ийн ахисан түвшний сургалт намар, хавар, өвөл+зун гэсэн 3 үндсэн улиралтай байх бөгөөд суралцагч жилд 2-оос илүү улиралд хичээл сонгон судлах боломжгүй. Нэг улирлын үргэлжлэх хугацаа 16 долоо хоног байх бөгөөд үүнд, үндсэн сургалт, бие даан суралцах, судалгааны ажил, семинар, хэлэлцүүлэг зэрэг багтана.

Сургалтын төлөвлөгөө:

Бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба нь хариуцсан сургалтын төлөвлөгөө, тухайн улиралд судлах хичээлийн хөтөлбөр, багшийн мэдээллийг хичээл сонголт эхлэхээс өмнө мэдээллийн системд байршуулж, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтэн, оюутанд үйлчлэх ажилтан хамтран, суралцагчдад шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгдөг. Иймээс суралцагч докторант нь өөрийн суралцах докторын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөтэй нэг бүрчлэн танилцаж, хичээл сонголт хийх, судалгааны ажил бичих гэх мэт өөрийн суралцах үйл явцыг нарийвчлан төлөвлөх шаардлагатай.

Докторын сургалтын төлөвлөгөө нь 60 кредитээс багагүй хэмжээтэй, дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Мэргэжлийн суурь хичээл 12 кредит
- Мэргэшүүлэх хичээл 18 кредит
- Судалгааны ажил (судалгааны семинар, диссертацийн ажил) 30 кредит

Суралцагч нь сургалтын төлөвлөгөөний хичээлийг бүрэн судалснаар докторын диссертаци бичиж хамгаалах эрхтэй болно. Сургалтын кредит цагаа бүрэн судалсан суралцагчид МУБИС-ийн докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаалаар гэрчилгээ олгоно. Суралцагч нь тухайн хөтөлбөрийн хүчинтэй хугацаанд үргэлжлүүлэн суралцаж судалгааны кредитээ гүйцээн докторын диссертаци бичиж хамгаална.

Ахисан түвшний сургалтын төлөвлөгөөний хичээл, эрдэм шинжилгээний ажлын багтаамж нь дараах бүтэц, агуулгын чиглэлтэй байна.

№	Агуулгын бүтэц	Агуулгын чиглэл
1	Мэргэжлийн суурь хичээл	Судалгааны чиглэлтэй холбоотой мэдээлэл эрж хайх, тоо баримт цуглуулах, ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж судлах, мэдээллийг боловсруулах, загварчлах, судалгааны программаар боловсруулалт хийх, тооцоолох, туршилт хийх.

		судалгааны ажлаа тайлагнаж, илтгэл тавих, өгүүлэл бичиж сурахад чиглэнэ.
2	Мэргэшүүлэх хичээл	Мэргэшүүлэх хичээл нь нарийн мэргэжлээр судлаачийн эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна. Удирдагч багшийн удирдлагаар бие даан судалж илтгэх, хичээлийн агуулгын зарим хэсгийг мэргэжлийн семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж реферат бичих, тохиолдлын судалгаа (case study) хийх, шалгалт өгөх хэлбэрээр кредит тооцуулахыг зөвшөөрнө. Докторант нь 6 кредит хичээлийг бусад тэнхим, сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгон судалж болно. Энэ нь мэргэшүүлэх хичээлийн кредитэд багтана.
3	Судалгааны ажил	Онолын ба судалгааны семинарыг удирдагч багшийн удирдлагаар докторант 6 кредит (3 кр онолын, 3 кр судалгааны семинар) кредит цаг судална. Докторын ажил нь 24 кредит байна. Докторантын судалгааны ажлын 24 кредитийг тухайн ажлын үр дүнг мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд хэвлүүлж, 2 тэнхимээр хэлэлцүүлж шаардлага хангасан тохиолдолд тооцно.

Судалгааны төсөлт ажлын, судалгааны болон онолын семинарыг албан ёсны удирдагч багш удирдах бөгөөд суралцагч дараах ажлуудыг хийж гүйцэтгэн кредит тооцуулна.

Үүнд:

- Эрдэм шинжилгээний их семинарт хамрагдсан бол 0.5 кр;
- Судалгааны ажлаа тэнхимийн болон бусад их семинарт хэлэлцүүлсэн бол 1 кр;
- Их дээд болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 1.5 кр;
- Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 2 кр;
- Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 3 кр;
- МУБИС-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 2 кр, мэргэжлийн түвшинд хянагддаг гадаад хэл дээр хэвлэгддэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 3 кр;
- Удирдагч багшийн хэрэгжүүлж буй МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөлд оролцсон бол 1 кр, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй дотоодын төсөлд оролцсон бол 2 кр, гадаадын санхүүжилттэй төсөлд оролцсон бол 3 кр;
- Сэдвийнхээ хүрээнд Web of Science болон Scopus-ийн индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 6 кр;

Хичээл сонголт:

Хичээл сонголтыг сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандарт, тодорхойлолтыг үндэслэн хийнэ. Ингэхдээ тэнхим, хөтөлбөрийн албаны мэргэжилтний зөвлөмжийн дагуу, хичээл сонгох, цуцлах, баталгаажуулах үйл ажиллагааг хийнэ.

Хичээл сонголтыг 2 үе шаттайгаар цахим хэлбэрээр хийнэ. Тухайн улиралд судлах хичээлийг "Сонголт-1"-ээр, хичээл заах багш, хичээллэх өдөр, цагийг "Сонголт-2"- оор баталгаажуулна. Суралцагч Сонголт 1, 2-ыг тухайн улирлын "0" долоо хоногт цахимаар хийж, хичээлийн хуваарийг хэвлэн гарын үсгээ зурж баталгаажуулан хариуцсан хөтөлбөрийн албаны мэргэжилтэнд өгнө. Суралцагч нэг улиралд 15 хүртэл кредит судлах ба үүнд судалгааны ажлын кредит хамаарахгүй. Нэг улиралд судлах кредитийн доод хэмжээ 10 кредит байна. Хичээл сонгож баталгаажуулаагүй суралцагчийг хичээлд суулгахгүй.

Суралцагч бусад их сургуулиас хичээл судлах үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу төрийн өмчийн бусад их сургуулиас хичээл сонгон судалж болно. Үүнд:

- Өөрийн хөтөлбөрт багтсан тодорхой хичээлийг дүйцүүлэх;
- Өөрийн хөтөлбөрийн чөлөөт сонголтын, эсвэл бусад нэгжээс судлахаар тодорхойлсон хичээлийн нэр заагаагүй багцын биелэлтэд тооцуулах;
- Өөрийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт хичээл сонгох;

Багцад тооцуулах зорилгоор бусад сургуулийн ижил түвшний хөтөлбөрийн хичээл солилцооны системд бүртгэлтэй хичээлээс сонгон судалж болно. Суралцагч өөрийн сонирхлоор бусад сургуулиас нэмэлт хичээл сонгон судлах тохиолдолд уг хичээлийг суралцаж буй хөтөлбөрийн кредит цагийн биелэлтэд тооцохгүй.

Суралцагч тухайн улиралд судлах хичээлээ сонгож, сургалтын төлбөр төлснөөр сурах эрхтэй болно.

Сургалтын төлбөр

1. Сургалтын төлбөрийг судлах хичээлийн кредитийн үнэлгээгээр тогтооно.
2. Суралцагч нь сургалтын төлбөрийг хичээл "Сонголт-2"-ыг хийхээс өмнө төлсөн байна.
3. Суралцагч нь тодорхой байгууллага, хувь хүний тэтгэлэг, зээлд хамрагдан сургалтын төлбөрөө төлж болно.

4. Суралцагч нь МУБИС-ийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах тохиолдолд докторын судалгааны ажлын 24 кредитэд сургалтын төлбөрийн аливаа хөнгөлөлт тооцохгүй.

Гадаад хэлний шалгалт:

Докторант нь сургалтын төлөвлөгөөний хичээлийн 20 кредит цагийг судалсны дараа гадаад хэлний шалгалт өгнө. Гадаадын суралцагч нь гадаад хэлний шалгалтыг ToPМОН (Монгол хэлний түвшинг тогтоох сорил) өгч дундаас дээш оноотой бол тооцуулж болно. Гадаад хэлний шалгалтад хангалттай дүн авч чадаагүй суралцагч докторын диссертацийн хамгаалалтад орох эрхгүй болох ба төлбөртэйгөөр дараагийн улиралд дахин шалгалт өгч болно.

Удирдагч ба судалгааны ажлын төлөвлөгөө:

Бүрэлдэхүүний сургууль нь мэргэжлийн тэнхим, профессор багш, суралцагчийн саналд тулгуурлан суралцагч нэг бүрээр судалгааны ажлын сэдэв, удирдагчийн нэрийг гаргаж, МУБИС-ийн захирлын тушаалаар улиралд 1 удаа баталгаажуулна. Докторант нь шаардлагатай тохиолдолд 2 удирдагчтай байж болно.

Удирдагч багшийн үүрэг:

- Удирдагч нь докторантын судалгааны ажлын сэдэв, төлөвлөгөөг чиглүүлэн тогтоож, гүйцэтгэлийг нь хянаж, туршилт хийх, үр дүнг боловсруулах, задлан шинжлэх, өгүүлэл бичих, илтгэл тавих зэрэг үйл ажиллагааг удирдан чиглүүлж, докторын сургалт судалгааны семинарыг тогтмол зохион байгуулна.
- Удирдагч нь докторын диссертац бичихэд зөвлөн тусалж, агуулга, чанар, судалгааны ажлын үр дүнгийн шинжлэх ухааны бодитой байдал, хууль эрх зүйн хүрээнд хийсэн эсэхийг хянадаг байна.

Докторантын эрх, үүрэг:

- Суралцагч нь диссертацийн сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшилцөн боловсруулж, тэнхимийн эрхлэгчээр хянуулан хөтөлбөрийн албаны даргаар баталгаажуулсан байна.
- Докторант нь судалгааны ажлаа тодорхой төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж тайлагнах бөгөөд удирдагч нь зөвлөн тусалж, хянаж чиглүүлэн - тэмдэглэл хөтөлнө.

- Докторант нь удирдагч болон судалгааны ажлын сэдвээ өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүний сургуулийн саналыг үндэслэн МУБИС-ийн захирал тушаал гаргаж шийдвэрлэнэ.

3. Төгсөх үйл явц

Докторын диссертац:

Шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдсэн, урьд өмнө хийгдсэн, мэдэгдэж буй бусад шийдэлтэй харьцуулж, шинэлэг талыг нээн харуулсан, зохих загвар, шаардлагыг баримталсан, тухайн сэдвээр онол, практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний ажил байна.

Докторын диссертацыг МУБИС-ийн захирлын тушаалаар баталсан загвар, шаардлагын дагуу бичиж хэвлүүлнэ.

Докторын диссертац урьдчилсан хамгаалалт:

- Сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн, гадаад хэлний шалгалт өгсөн, сургалтын төлбөрөө бүрэн төлсөн баримтыг үндэслэн горилогчийн диссертацыг хэлэлцэх их семинарыг 2-оос доошгүй мэргэжлийн тэнхим (профессорын баг) дээр хэлэлцүүлнэ. Их семинарын товыг нийтэд зарлаж, бусад их сургууль, судалгаа шинжилгээний байгууллагын эрдэмтдээр өргөтгөн зохион байгуулна.
- Докторантын судалгааны ажлын ажлын сэдэв, бүтцийг 5-р улиралд тэнхимээр хэлэлцүүлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл дахин хэлэлцүүлж болно. Докторант тэнхимийн хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийн дагуу судалгааны ажлын сэдэв, бүтцийг засан сайжруулж, үргэлжлүүлэн бичнэ.

Докторын диссертац хуулбарлалт шалгах:

Хоёр их семинарын хэлэлцүүлгээс диссертацыг эрдэм шинжилгээний шаардлага хангасан хэмээн үзсэн, бүтээлийн хуулбарлалтыг шалгах программаар уншуулж зохих шаардлага хангасан тохиолдолд эрдэм шинжилгээний удирдагч нь холбогдох материалын хамт докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хүсэлт гаргана. Шаардлага хангаагүй тохиолдолд горилогч ба удирдагчид ажлыг дахин сайжруулахаар буцаана.

Докторын диссертац жинхэнэ хамгаалалт:

- Докторын диссертацаа хамгаалж чадаагүй бол 3 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтад орох хүсэлтээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргад гаргаж шийдвэрлүүлнэ.
- Диссертацыг монгол хэлээр бичнэ. Диссертацын тухай товч танилцуулгыг, англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, хавсаргана.
- Амжилттай хамгаалсан тохиолдолд хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг Ахисан түвшний хөтөлбөрийн албанд ирүүлнэ.

Докторын диссертац хүлээлгэж өгөх

Хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь амжилттай хамгаалсан докторын дараах материалыг бүрдүүлэн МУБИС-д ирүүлнэ. Эдгээр материалыг дипломын хуулбарын хамт сургуулийн архив болон номын санд хадгална. Үүнд:

- а) Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
- б) Хамгаалуулах зөвлөлийн хурлын протокол, тогтоол
- в) Удирдагчийн тодорхойлолт
- г) Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертац, түүний CD бичлэг 1 хувь
- д) Тооцоо хийсэн тойрох хуудас зэрэг орно.

Диссертацын хувийг Үндэсний номын сан, Мэдээллийн технологийн үндэсний парк, хамгаалах үйл ажиллагаа түшиглэсэн тухайн сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

Докторын зэрэг олгох, төгсөлт

Докторын диссертацыг амжилттай хамгаалсныг баталсан Хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, МУБИС-ийн захирлын тушаалаар докторын зэрэг олгох шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг үндэслэн МУБИС докторын зэргийн дипломыг дүрэм журмын хүрээнд хэвлэн баталгаажуулж, гардуулах ажлыг зохион байгуулна. Докторын зэрэг олгох төгсөлтийг улиралд 1 удаа тус тус хийнэ.

БҮЛЭГ V. МУБИС-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ

Мэдлэг, чадварыг үнэлж, дүгнэх:

- Сургалтын төлөвлөгөө дэх хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь явцын үнэлгээ байх ба хүрсэн түвшин болон үр дүнгийн үнэлгээг хичээл заасан багш 100 хувь хийнэ.
- Оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах кредитээр нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг кредитийн нийлбэрт хувааж (арифметикийн жигнэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot D_i}{\sum_{i=1}^n K_i}$$

- n - хичээлийн тоо
- K_i - тухайн (i) дугаар хичээлийн кредит цаг
- $O_i(D_i)$ - тухайн (i) дугаар хичээлийн оноо (дүн)
- ГО(ГД) - голч оноо (голч дүн)
- Оюутан улирал бүр тухайн улирлын, мөн суралцсан нийт хугацааны голч оноо болон голч дүнтэйгээ танилцан, сурлагынхаа байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.
- Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хамааралтай байна. Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн голч дүн	Магистрант, докторант
98-100	A+	4.3	Тэнцсэн
94-97	A	4.0	
91-93	A-	3.7	
88-90	B+	3.3	
84-87	B	3.0	
81-83	B-	2.7	
78-80	C+	2.3	
74-77	C	2.0	Тэнцээгүй
71-73	C-	1.7	
68-70	D+	1.3	
64-67	D	1.0	
61-63	D-	0.7	
30-60	F	0	голч тооцохгүй
0-29	W		

- Оюутныг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнгээс гадна **I, W, WF, S, U** гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээг оюутны голч дүн буурах шалтгааныг тогтоох, оюутанд голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох,

мөн бусад сургуулийн кредитийг шилжүүлэн тооцох зэрэгт ашиглана. Үүнд:

Тэмдэглэгээ	Тайлбар
I (Incomplete)	Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ (даалгавар, дадлагын ажил дутуу, явцын шалгалтад орж чадаагүй гэх мэт) дутуу бол Сургалтын журмын 4.6.18-д заасан хугацаанд нөхөн гүйцэтгэж, шалгуулах нөхцөлтэйгөөр хэрэглэнэ.
W (Withdraw)	Оюутны мэдлэг, чадварыг бодитой үнэлэх боломжгүй, өөрөөр хэлбэл хичээлийн 2/3-д суугаагүй эсвэл даалгавар, бие даалт, явцын болон эцсийн шалгалтыг өгөөгүй, 0-29 хүртэл хувьчилсан үнэлгээ авсан тохиолдолд уг тэмдэглэгээ хийнэ. Энэ тохиолдолд шинээр судлах хичээл гэж үзнэ.
WF (Withdraw Failing)	Оюутны тухайн улиралд судлах даалгаврын ачаалал ихдэж, хичээлийн агуулгыг судлах, даалгавар бие даалтыг хийж амжихгүй нь тодорхой болсон тохиолдолд багшаас санаачлан оюутантай зөвшилцөн улирлын дундаас уг тэмдэглэгээг хийж хичээлээс чөлөөлж болно. Энэ тохиолдолд шинээр судлах хичээл гэж үзнэ.
S (Satisfactory) “Тооцов” тэмдэглэгээ.	Сургалтын төлөвлөгөөнд заасан нийгэм, хүмүүнлэгийн болон сургууль олон нийтийн ажил гүйцэтгэх хөтөлбөрийг заавал болон сонгон судалсан, мөн тусгай тэмдэглэл хийсэн нэмэлт хөтөлбөр судалсан бол энэхүү тэмдэглэгээг хийнэ.
U (Unsatisfactory) “Үл тооцов” тэмдэглэгээ.	
A, B, C, D, F (үнэлгээ)	Оюутны мэдлэг, чадварыг А, В, С, D, F гэсэн үнэлгээгээр үнэлсэн тохиолдолд оюутны хүсэлтийг харгалзан улирлын төгсгөлд W, WF тэмдэглэгээ болгон өөрчлөхгүй.

- I тэмдэглэгээтэй оюутан нь дараагийн улирлын эхний I сард багтаан дүнгээ гаргуулах бол бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанаас I тэмдэглэгээг баталгаажуулна. I тэмдэглэгээтэй оюутнаас нэмэлт төлбөр авахгүй.
- Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн кредит цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүн бодоход хэрэглэхгүй.

***Ахисан түвшний хөтөлбөрийн суралцагч нь тухайн хичээлийг судалж, 71 (C-) ба түүнээс дээш үнэлгээ авсан тохиолдолд тухайн кредит цагийг биелүүлсэнд тооцно. (C-) үнэлгээнээс доогуур оноо авсан тохиолдолд тухайн хичээлд ногдох кредитийн төлбөрийг төлж дахин судална.

Чөлөө авах:

1. Суралцагчийн хүсэлтийг үндэслэн улирлын, жилийн чөлөөг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар олгоно. Чөлөөг сунгах, дахин олгох хүсэлтийг бичгээр гаргана.

2. Суралцагч чөлөө авсан тохиолдолд тухайн улирлын хичээлд суусан хугацааны төлбөрийг суутгаж, үлдсэнийг нь үргэлжлүүлэн суралцахад ашиглана.
3. Суралцагч чөлөөний хугацаагаа дуусгалгүй үргэлжлүүлэн сурахаар бол бичгээр хүсэлт гаргаж, захирлын тушаалаар үргэлжлүүлэн суралцуулна.

Сургуулиас чөлөөлөх:

4. Албан ёсны зөвшөөрөлгүйгээр 2 улирал дараалан сургалтад хамрагдаагүй, судалгааны ажил хийгээгүй, сургалтын төлбөрөө төлөөгүй магистрант, докторантыг сургуулиас хасна.
5. Суралцагч сурлага, ёс зүйн асуудлаар хасагдах болон хүсэлтээрээ чөлөөлөгдөх үед улс, захиалагч байгууллагаас төлсөн зардлыг буцааж төлөх асуудлыг суралцагч өөрөө хариуцна.
6. Сургуулиас чөлөөлөгдсөн суралцагч дахин сурах хүсэлт гаргасан тохиолдолд өмнө судалсан хичээлийг тухайн хичээлийн жилд хэрэгжиж буй сургалтын төлөвлөгөөнд дүйцүүлэн тооцно. Дүйцүүлэлтийг МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журмаар зохицуулна.
7. Тодорхой шалтгааны улмаас захирлын тушаалаар сургуулиас чөлөөлөгдсөн боловч үргэлжлүүлэн суралцах хүсэлт гаргасан магистрант, докторантыг сургалтын төлөвлөгөө дэх хичээлүүдийг судалж зохих кредитээ цуглуулсныг харгалзан үргэлжлүүлэн суралцуулж болно. Үргэлжлүүлэн суралцах хүсэлт гаргасан магистрант 2 кредит, докторант 3 кредиттэй тэнцэх хэмжээний төлбөр төлнө.

Шилжилт, хөдөлгөөн:

- Магадлан итгэмжлэгдсэн, МУБИС-ийн кредит цагийг хүлээн зөвшөөрсөн их сургуульд амжилттай суралцаж байгаа магистрант, докторантыг өөрийн хүсэлт, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлын зөвшөөрлийг үндэслэн шилжүүлэн суралцуулж болно.
- МУБИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцахаар бол мэргэжил хоорондын кредитийн зөрүү, хамрагдаж буй тэтгэлэг, хөнгөлөлт, сургалтын төлбөрийн өргүй байх зэргийг харгалзан үзэж магистрант, докторантын өөрийн хүсэлт, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлын зөвшөөрлийг үндэслэн шилжүүлэн суралцуулж болно.

- МУБИС-тай кредит харилцан хүлээн зөвшөөрөх боломжтой гадаадын их сургуульд суралцаж цуглуулсан магистрантын 10 хүртэл, докторантын 20 хүртэл, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэл хийлгэсэн дотоодын их сургуульд суралцаж цуглуулсан магистрантын 6 хүртэл, докторантын 9 хүртэл кредитийг дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэх үйл ажиллагааг МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журмаар зохицуулна.
- Шилжин суралцах хүсэлт гаргах суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - а. Шилжин суралцах шалтгаанаа тодорхой бичсэн өргөдөл
 - б. Суралцаж байгаа сургуулийн суралцагч мөн болохыг баталсан тодорхойлолт
 - с. Сургуульд элссэн тушаалын хуулбар
 - д. Тухайн сургуулиас чөлөөлөгдсөн тушаал
- Дээр заасан баримт бичиг гадаад хэлээр бол албан ёсны орчуулга хийлгэж, нотариатаар батлуулсан байна.
- Шилжин суралцах тухай өргөдөл болон бусад бичиг баримтын хамт тухайн улирлын хичээл эхлэхээс 2 долоо хоногийн өмнө бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хөтөлбөрийн албанд ирүүлнэ.
- Хэрэв өргөдөл хүлээж авах хугацаанд дээрх бичиг, баримтыг ирүүлээгүй бол тухайн суралцагчийн хүсэлтийг дараагийн улирлын шилжилт хөдөлгөөнөөр шийдвэрлэнэ.

Магистрант, докторант туслах ажилтнаар ажиллах:

МУБИС-ийн салбар сургууль, тэнхим, алба, нэгжүүд нь хичээлийн жилийн эхэнд тухайн ажлын байранд шаардлагатай туслах ажилтны эрэлт хэрэгцээг судлан тоог гаргаж, болзол хангасан магистрант, докторантыг сонгон шалгаруулж, нөөцөд авна. Докторант нь туслах багш, туслах судлаач, захиргааны туслахаар, магистрант нь туслах судлаач, захиргааны туслахаар ажиллаж болно.

Туслах ажилтанд тавих шаардлага, шалгуур:

1. МУБИС-ийн магистрант, докторант байх;
2. Гадаад хэл, судалгааны арга зүй, мэдээлэл харилцааны технологийг зохих түвшинд эзэмшсэн, багаар ажиллах чадвартай байх;
3. МУБИС-ийн эрхэм зорилго, эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх ба хавсарга судалгааны чиглэл, холбогдох дүрэм, журмын хүрээнд ажиллах;

4. Докторант судалгааны ажлын 40-өөс доошгүй хувийн гүйцэтгэлтэй, нийт кредитийн 1/3-ийг цуглуулсан, өмнөх боловсролын зэргийн голч нь 3.0-оос дээш байх;
5. Магистрант нийт кредитийн 1/3-ийг цуглуулсан, өмнөх боловсролын зэргийн голч нь 3.0-оос дээш байх;
6. Ажил олгогч нэгж туслахаар ажиллах зөвшөөрөл олгосон байх;
7. Туслах багш нь багшлах эрхийн сертификаттай, гадаад хэлний олон улсын
8. шалгалтын хүлээн зөвшөөрөгдсөн оноотой бол давуу тал болох;
9. Гадаад магистрант, докторант нь монгол хэлний ярианы болон бичгийн харилцааны өндөр чадвартай байх;

Туслах ажилтны эрх, үүрэг:

- Туслах ажилтан орон тооны бус байх бөгөөд иргэний гэрээнд заасан ажил, үүргийг гүйцэтгэнэ.
- Захиргааны туслах ажилтан гэрээний дагуу 7 хоногт 20 хүртэл цаг ажиллана.
- Туслах ажилтан хувийн зохион байгуулалт болон харилцааны соёл өндөртэй байж, МУБИС-ийн эрхэм зорилго, холбогдох дүрэм журмын хүрээнд ажиллана.
- Туслах ажилтны гэрээний хугацаа 12 сар хүртэл байх ба ажлын биелэлтийн үнэлгээ 75 хувиас дээш авсан нөхцөлд нэг удаа сунгаж болно.
- Туслах ажилтан хүндэтгэх шалтгаанаар гэрээг цуцлах хүсэлт гаргаж болно.
- Зохих болзол бүрэн хангасан гадаад магистрант, докторант туслах ажилтны сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

Туслах ажилтны үнэлгээ

Туслах ажилтны гэрээний үр дүнг тооцох ба сунгах зорилгоор улирлын эцэст ажил олгогч нэгж гэрээнд заасан ажлын биелэлт, чанар, үр дүн, цагийн тооцооны биелэлтийг хэлэлцэж, 75 хувиас дээш үнэлгээ авсан нөхцөлд "хангалттай" гэж үнэлнэ.

Сургуулиас олгох албан ба албан бус бичиг баримт

Оюутны үнэмлэх: МУБИС-д оюутнаар элсүүлэх тухай захирлын тушаал гарсан тохиолдолд суралцагчдад оюутны үнэмлэх олгоно. Үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд нөхөн авч болно.

Дүнгийн тодорхойлолт: МУБИС-ийн оюутан мөн болох тухай, мөн суралцаж байх хугацааны дүнгийн албан ёсны тодорхойлолтыг бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба олгоно. Дүнгийн албан бус тодорхойлолтыг оюутан мэдээллийн

сангаас төлбөргүй авч болно. Суралцаж буй хугацааны дүнгийн тодорхойлолтод тухайн оюутны судалсан хичээлээр авсан нийт дүн (амжилтгүй авсан дүн мөн адил хамаарна)-г оруулна.

Диплом, энгэрийн тэмдэг: МУБИС-ийн журмын дагуу амжилттай сурч, дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан оюутныг төгсөхөд тухайн боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг олгоно.

Төгссөн тухай тодорхойлолт, дипломын хавсралт дахь дүнгийн тодорхойлолт, лавлагаа: Төгссөн тухай тодорхойлолт, дипломын хавсралт дахь дүнгийн албан ёсны магадлгааг сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба олгоно. Дипломын хавсралт дахь дүнгийн жагсаалтад оюутны суралцаж байх үедээ амжилтгүй авсан дүнг оруулахгүй.

Төгсөгчийн хаясан, гэсэн, устаж үгүй болсон, ашиглах боломжгүй, буруу хэвлэгдсэн диплом: МУБИС-ийг төгссөн бакалавр, магистр, докторын сургалтын төгсөгчийн хаясан, гэсэн, устаж үгүй болсон, ашиглах боломжгүй болсон, овог нэр солих дипломыг төгсөгчийн хүсэлтээр холбогдох материал бүрдсэн тохиолдолд нөхөн олгоно.

- Нөхөн олгож буй дипломд төгссөн үеийн тушаалын огноо, хуучин дипломын дугаар тавигдах бөгөөд одоо ажиллаж байгаа захирал, холбогдох хүмүүсийн гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажна.
- Диплом нөхөн авахад дипломын материалын өртөг болон үйлчилгээний хураамжид 3 кредитийн төлбөр төлнө. Төлбөрийг тухайн жилийн кредитийн суурь үнэлгээгээр тооцно.

Тодорхойлолт, лавлагаа: Хувь хүний хүсэлтээр тодорхойлолт, лавлагаа монгол хэлээр гаргахад 5.000 төгрөг, англи хэлээр гаргахад 10.000 төгрөг тус тус үйлчилгээний төлбөрт авна.

БҮЛЭГ VI. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

Улаанбаатар нь Монгол Улсын нийслэл бөгөөд Монгол улсын цорын ганц саятан хот юм. 1992 оны шинэ нутаг дэвсгэрийн хуваарьар үндсэн 6, дагуул 3, нийт 9 дүүрэгтэй, нутаг дэвсгэрийн хэмжээ 4,704.4 км² газартай. 2021 оны эцсээр 1,649,172 хүн оршин сууж байна.

Улаанбаатар хот Монгол Улсын төв хэсэгт Туул-Сэлбийн гол бэлчир хөндийд, далайн түвшнээс дээш 1300-1350 метр өндөрт Богд хан, Сонгино хайрхан, Чингэлтэй уул, Баянзүрх дөрвөн уулаар хүрээлэгдэн оршдог.

1778 он хүртэл Монгол улсын нийслэл нь олон газар нүүдэллэж байгаад одоогийн байрлалдаа тогтсон. Өмнө нь шашин, худалдааны төв байсан бол 1911 оноос улсын нийслэл болж, XX зуунд барилгажиж, аж үйлдвэржиж, XXI зуунд их хотын төрх бүрдэж байна. Улаанбаатар Монгол Улсын улс төр, эдийн засаг, соёл, технологийн төв юм.

Хүн ам: Монгол улсын хүн ам 3 сая үүний 1.6 сая хүн нь Улаанбаатар хотод амьдардаг.

Уур амьсгал: Улаанбаатар нь маш өндөр газарт оршдог учраас дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог. Жилийн дундаж температур нь -1.3 °C. Богино, дулаан зунтай бөгөөд урт, маш хүйтэн, хуурай өвөлтэй. Улаанбаатар хотын өвлийн дундаж температур нь -25°C хүрдэг.

Засаг захиргааны нэгж: Дүүрэг нь нийслэлийн засаг захиргааны нэгж юм. Нийслэл 9 дүүрэгтэй бөгөөд тэдгээр нь цааш хороодод хуваагдана. Дүүргүүдийн нэр нь Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай.



Улаанбаатар хотын дүүргүүд

Нийтийн тээвэр: Улаанбаатар хотын нийтийн тээвэр нь хотын тээврийн үндсэн систем бөгөөд Улаанбаатар хотод зорчих хамгийн хямд арга зам юм. Нийслэлийн хэмжээнд 21

аж ахуйн нэгжийн өдөрт 1200 гаруй автобус 79 чиглэлд иргэдэд үйлчилдэг. Түүнчлэн Улаанбаатар хотоос бусад аймгийн хот, суурин руу холын зайн автобусны сүлжээтэй.


Нийтийн автобус найдвартай, байнга явах нь давуу талтай байдаг. Зарим маршрутууд хөл хөдөлгөөн ихтэй байдаг. Мөн өглөө ажил цуглах, орой ажил тарах үеэр нийтийн тээврийн автобус ачаалал ихтэй байдаг. Хэрэглэгчид UB Smart Bus программыг ашиглан автобусыг хянах, автобусны зогсоолыг олох боломжтой. Хэрэглээний цэс нь англи хэл дээр, автобусны шугам, зогсоол монгол кирилл үсгээр бичигдсэн байдаг.

Нийтийн автобусны үнэ, U money автобусны карт: Улаанбаатарт нэг талдаа автобус 500, троллейбус 300 төгрөг. 2016 оноос хойш автобусанд бэлэн мөнгөөр төлбөр хийдэггүй тул та U money автобусны картыг 3600 төгрөг төлж авах шаардлагатай. Анх худалдан авсан карт мөнгөгүй тул цэнэглэх хэрэгтэй. Карт цэнэглэх доод хэмжээ 500 төгрөг, дээд тал нь 90000 төгрөг байна. 30 минутын дотор автобус солих үед дамжин өнгөрөх нь үнэ төлбөргүй.

Нийтийн автобусыг хэрхэн ашиглах вэ?

1. U-money автобусны карт худалдаж аваад цэнэглэнэ. Та U-money автобусны картыг (3600₮) томоохон автобусны зогсоолууд, Circle K, CU, V point дэлгүүрүүдээс авах боломжтой. Circle K, CU, V point дэлгүүрүүд 24 цагаар ажилладаг. Картыг хүссэн хэмжээгээрээ цэнэглээрэй.
2. Автобусны зөв шугамыг ол. Бүх автобус явах шугамаа автобусны урд кирилл үсгээр бичсэн байдаг. Автобусанд хамгийн ойр байрлах автобусны зогсоол руу оч. Автобусны тэмдгийг санаж, түүнийг дагаарай.
3. Автобусанд урд хаалгаар орж, жолоочийн хажууд байрлах төлбөр төлөх машин дээр картаа товш. Англи хэл дээр мэдээлэл байхгүй тул Google газрын зураг ашиглан аяллаа хянах нь илүү сайн арга юм.
4. Буруу автобусанд суусан бол дараагийн зогсоолоос буу. 30 минутын дотор үнэгүй нэвтрэх эрхийг ашиглахын тулд буух хаалганы дэргэд байх машин дээрх картыг дараарай.
5. Автобусны дунд эсвэл арын хаалгаар буулгана. Буухаасаа өмнө хаалганы дэргэдэх машин дээр картыг товшоорой

Нийслэлийн Тээврийн газраас 2019 онд шинээр ашиглалтад орсон Улаанбаатар хотын нийтийн тээвэр үйлчилгээний 40 гаруй чиглэлүүдийг танилцуулж байна.



Зураг 3. Улаанбаатар хотын нийтийн тээвэр үйлчилгээний чиглэл

Гадаад оюутны визны мэдээлэл

Монгол улсад суралцах гадаад суралцагчдад Е2 ангиллын визийн зөвшөөрөл олгодог.

Гадаад суралцагч бүрдүүлэх бичиг баримтууд:

1. Паспорт болон паспортыг орлох баримт бичгийн хуулбар /паспортын хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байна/
2. Санхүүгийн баталгаа /Сургалтын төлбөрийг хувь хүнээс гаргасан санхүүгийн баталгаа/
3. Эрүүл мэндийн хуудас /сүүлийн 3 сарын дотор эмнэлгээс олгосон байх/
4. Суралцах гэрээ
5. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт /Голомт банкны 1320000052 тоот дансанд 2500 төгрөг төлнө/ Гүйлгээний утга дээр паспортын дугаар болон нэрээ бичнэ.
6. Мэдүүлгийн хуудас /3*4 хэмжээтэй зураг/

7. Суралцагчийн ерөнхий мэдээллийг үнэн зөв бичиж явуулах /өөрийн орон дахь гэрийн хаяг, утасны дугаар, эмайл хаяг, ажилладаг бол ажлын газрын нэр, албан тушаал, ажлын газрын утасны дугаар, өөрийн орон дахь ойрын холбоо барих хүний нэр, утасны дугаар/

Санамж:

- Визийн зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 60 хоногийн дотор хүчинтэй байна.
- Визийн зөвшөөрөл аваад хилээр орж ирсний дараа гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгэл хийлгэнэ. Бүртгэлийг тус сургуулийн визийн зөвшөөрөл явуулсан ажилтан цахимаар хийнэ. 48 цагийн дотор бүртгэл хийлгээгүй тохиолдолд торгуулийн арга хэмжээнд орно.
- Суралцагч оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.
- Баримт бичийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн, худал мэдүүлж виз авсан нь тогтоогдсон бол 180 хоног, бусад үндэслэлээр татгалзсан бол 30 хоногийн дараа хүсэлтээ дахин гаргаж болно.
- Визийн зөвшөөрөл шийдвэрлэх хугацаа: Ажлын 5 хоног

Гадаад оюутанд хэрэгтэй мэдээ, мэдээлэл

Монгол улсад гадны улсаас суралцахаар ирж буй оюутнуудад шинэ орчинд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, Монгол соёл болоод амьдралын хэв маягийн талаар олон талт бодитой мэдээлэл олгох зорилгоор МУБИС-ийн зүгээс мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан дараах мэдээллийг олгодог. Үүнд:

- Монгол улсын түүх соёл, үндэсний онцлог, газар зүйн байршил уур амьсгал, хүн амын талаарх ерөнхий мэдээллийг олгох
- Монгол улсын газар нутагт мөрдөгдөж буй хууль дүрэм, гадны иргэдийн эрх зүйн мэдлэггүй байдлаас үүдэн холбогдсон гэмт хэргүүд, тэдний хамгийн их хохирч буй гэмт хэргүүдийн талаар холбогдох байгууллагатай хамтарсан мэдээлэл олгох цаашлаад Монголчуудын зан заншил, шашин шүтлэг, цэрлэх ёс зэргийн талаар мэдээлэл олгох.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй залуучуудад зориулсан үзвэр үйлчилгээний байгууллагууд тэдгээрийн үнэ тарифын талаар мэдээлэл олгох

- Болзошгүй өвчин, осол аюул зэргээс урьдчилан сэргийлэх, түргэн тусламжийн үйлчилгээ зэргийн талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл олгох
- Монгол үндэсний зоог, хоол хүнс болон чанартай шинэ хүнсийг хаанаас худалдан авч болох, мөн өдрийн цагаар хямд үнээр шим тэжээллэг хүсний бүтээгдэхүүн, хоолоор үйлчилдэг газруудын мэдээлэл олгох
- Оюутан залууст зориулсан сайн дурын болон бусад байдлаар өөрийгөө хөгжүүлэх боломж бүхий байгууллагуудын танилцуулгыг хүргэх
- Монгол улсад ашиглагддаг түгээмэл ухаалаг утасны хэрэглүүрүүд зэргийн талаар тайлбарлах гэх мэт үйл ажиллагаа хийгдэнэ.

Аюул тохиолдсон үед шаардлагатай дугаарууд:

Гар түймэр 101

Гамшиг осол, аврах ажиллагаа 105

Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол 102

Эмнэлгийн түргэн тусламж 103

Бүлэг I

Бүлэг II

Бүлэг III

Бүлэг IV

Бүлэг V

Бүлэг VI

Ашигласан материал:

1. МУБИС-ийн Математик, Байгалийн Ухааны Сургуулийн “Оюутны хөтөч” гарын авлага, 2019
2. МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн “Оюутны гарын авлага”, 2020
3. МУБИС-ийн Мэдээллийн технологийн алба боловсруулсан “Оюутны хөтөч”, 2020
4. МУБИС-ийн веб сайт
5. МУБИС-ийн “Дүрэм, Журам гэрээ, маягтууд” ном, 2019
6. МУБИС-ийн “Элсэлтийн журам”, 2023
7. МУБИС-ийн “Ахисан түвшний сургалтын журам”, 2023
8. www.wikipedia.org
9. <https://www.mymongoliatravel.com/transportation/ulaanbaatar-bus-and-route/>